



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ  
ҮНДЭСНИЙ ТӨВ

# ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ


СУДАЛГААНЫ ТАЙЛАН







НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ  
ҮНДЭСНИЙ ТӨВ

# ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2021 он

НАА 67.408  
ДАА 345  
Ш-663

## ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

### СУДАЛГААНЫ ТАЙЛАН

#### СУДАЛГААНЫ БАГ:

Ц.Алтанцэцэг, *Отгонтэнгэр Их сургуулийн багш, хуульч дэд профессор*  
С.Эрдэнэболор, *Отгонтэнгэр Их сургуулийн багш, хуульч, хууль зүйн докторант*  
Б.Энхбаяр, *Отгонтэнгэр Их сургуулийн багш, хуульч, хууль зүйн докторант*  
Б.Досжан, *Отгонтэнгэр Их сургуулийн багш, хууль зүйн докторант*  
Н.Арвинтариа, *ХЭҮТ-ийн захирал, хуульч, өмгөөлөгч*  
С.Байгалмаа, *ХЭҮТ-ийн хөтөлбөрийн менежер, эрх зүйч*  
Д.Санчир, *ХЭҮТ-ийн хуулийн зөвлөгч, эрх зүйч*

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Энэхүү тайланд туссан хөндлөнгийн дүгнэлт, үзэл бодол нь Нээлттэй Нийгэм Форумын байр суурийг илэрхийлэхгүй болно.

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9742-1-3

## ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ.....	4
ӨМНӨХ ҮГ.....	5
УДИРТГАЛ.....	6
Нэг. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ .....	10
1.1. ГБХ-ийн талаарх эрх зүйн зохицуулалт.....	10
1.2. Гэр бүлийн хүчирхийллийн холбоотой гэмт хэргийн талаарх Эрүүгийн эрх зүйн зохицуулалт.....	14
1.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нөхцөл байдал.....	17
1.4. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал.....	20
1.5. Фокус бүлгийн ярилцлага.....	27
1.6. Бүлгийн дүгнэлт.....	29
Хоёр. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА БАЙДАЛ .....	32
2.1. Эрүүгийн хуулийн зохицуулалт.....	33
2.2. Заналхийлэх гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал.....	44
2.3. Бүлгийн дүгнэлт.....	48
Гурав. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ .....	49
3.1. Эрүүгийн хуулийн зохицуулалт.....	49
3.2. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийг шийдвэрлэж буй байдал.....	58
3.3. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийг зарим улс оронд хуульчилсан байдал.....	61
3.4. Бүлгийн дүгнэлт.....	62
Дөрөв. ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГӨХ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ ...	64
4.1. Эрүүгийн хуулийн зохицуулалт.....	64
4.2. Хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргийг шийдвэрлэж буй байдал.....	68
4.3. БНТУ-ын Эрүүгийн хуульд тусгагдсан ижил төстэй зохицуулалт.....	70
4.4. Бүлгийн дүгнэлт.....	71
ДҮГНЭЛТ.....	73
ЗӨВЛӨМЖ.....	75
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	77

## ТОВЧИЛСОН ҮГ

БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГАТХ	Гүйцэтгэх ажлын тухай хууль
ЗтХ	Зөрчлийн тухай хууль
ЗШШТХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
МӨХ	Монголын өмгөөлөгчдийн холбоо
МУШТХ	Монгол Улсын Шүүхийн тухай хууль
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
УДШ	Улсын дээд шүүх
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

## ӨМНӨХ ҮГ

Манай улс 2015 онд баталсан Эрүүгийн хуулиараа Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалахад онцгой анхаарал хандуулж, 30 орчим шинэ төрлийн гэмт хэргийг хуульчилсан билээ. Тиймээс Нээлттэй Нийгэм Форум Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр гэмт хэрэгт тооцогдсон “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”, “заналхийлэх”, “ялгаварлан гадуурхах”, “мөрдөн мөшгөх” гэмт хэргийн шийдвэрлэлтийг судлахыг зорьсон болно.

“Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал” судалгааг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ эрхлэн явуулсан бөгөөд Танд уг судалгааны дүнг хүргэж байгаадаа баяртай байна. Энэ судалгаа нь дээр дурдсан шинэ төрлийн гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, шүүхээр шийдвэрлэсэн байдал, тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийж, холбогдох санал зөвлөмжийг боловсруулснаараа ач холбогдолтой. Харамсалтай нь зарим гэмт хэрэг хэд бүртгэгдсэн, хэд нь шүүхээр шийдвэрлэгдсэн болохыг олж тогтооход хүндрэлтэй байсан нь тухайн асуудлаар цогц шинжилгээ хийхэд хүндрэлтэй байсан болно. Мөн зарим төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт туйлын хангалтгүй байгаа нь хуульч, хууль сахиулагчдын мэдлэг, ур чадвар сул, иргэд энэ талаар сайн мэдэхгүйгээс эрхээ хамгаалж чадахгүй байгаа болон тухайн гэмт хэргийн нуугдмал шинж өндөр байгааг илтгэж байна.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд энэ хүрээнд 20 орчим судалгаа олны хүртээл болсныг энэ дашрамд дурдахад таатай байна. Мөн бид дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого шийдвэрт тусгуулах зорилгоор цуврал хэлэлцүүлгийг эхлүүлээд байгаа бөгөөд хэлэлцүүлгийн видеог Та бүхэн манай [www.fogum.mn](http://www.fogum.mn) цахим хуудас болон нийгмийн сүлжээнээс олж үзэх боломжтойг дуулгахад таатай байна. Бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал

## УДИРТГАЛ

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Эрүүгийн хуулийг (шинэчилсэн найруулга) 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж ирлээ. Эрүүгийн эрх зүйн тогтолцооны шинэчлэл нь шинээр хамгаалах шаардлагатай үнэт зүйлсийг Эрүүгийн хуульд тусгаж, хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг жинхэнэ утгаар хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн билээ.<sup>1</sup>

Эрүүгийн хуульд хүний орон байранд хууль бусаар халдах, хууль бусаар нэгжих, эд хөрөнгө хураан авах, битүүмжлэх, ялгаварлан гадуурхах, заналхийлэх, хууль бусаар мөрдөн мөшгөх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг 30 гаруй төрлийн гэмт хэргийг шинээр нэмсэн.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO), НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас Монгол Улсад хэрэгжүүлж буй гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээрх төсөл, хөтөлбөрийн хүрээнд ялгаварлан гадуурхах, заналхийлэх, мөрдөн мөшгөх зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаанд хийсэн ямар нэг судалгаа байхгүй байна.

Иймд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдол бүхий эдгээр гэмт хэргийг шалган шийдвэрлэж буй байдал, практикт тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг судалж, хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Энэ судалгааг Нээлттэй Нийгэм Форумын санхүүгийн дэмжлэгтэйгээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ эрхлэн Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн судлаачдын багтай хамтран гүйцэтгэсэн болно.

---

<sup>1</sup> Эрүүгийн хуулийн үзэл баримтлал



## Судалгааны хүрээнд дэвшүүлсэн зорилт

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Ялгаварлан гадуурхах”, “хууль бусаар мөрдөн мөшгөх”, “заналхийлэх”, “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулах, шүүхээс энэ төрлийн хэргийг үйлдсэн этгээдэд ял, албадлагын арга хэмжээ оногдуулж буй байдал, оногдуулж байгаа ял шийтгэл оновчтой байгаа эсэхийг шинжлэн судлах зорилгыг агуулсан бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- “Ялгаварлан гадуурхах”, “хууль бусаар мөрдөн мөшгөх”, “заналхийлэх”, “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг Эрүүгийн хуульд зохицуулсан байдал, энэ талаарх холбогдох зарим олон улсын гэрээ конвенц болон үндэсний хууль, эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх;
- Дээрх хуулийн зүйл, заалтыг практикт хэрхэн хэрэглэж байгааг судлах;
- Дээрх төрлийн гэмт хэрэгт хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг судлах;
- Шүүхээс эдгээр гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж буй байдал, ял, албадлагын арга хэмжээ оногдуулж буй байдалд дүн шинжилгээ хийх;
- Судалгааны санал, зөвлөмж бүхий тайлан боловсруулах.


## Судалгааны хүрээ, арга зүй

Судалгааны хүрээнд Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хуульд заасан “ялгаварлан гадуурхах”, “хууль бусаар мөрдөн мөшгөх”, “заналхийлэх”, “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн талаарх хууль, эрх зүйн зохицуулалт, цагдаагийн байгууллага, шүүхийн статистик мэдээллүүд, энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг хамрууллаа. Судалгааны зорилгыг хангах үүднээс холбогдох төрийн байгууллагаас мэдээ мэдээлэл авах, баталгаажуулах, тохиолдол шинжлэх, асуулга, лавлагаа, тайлбар авах, хууль эрх зүйн акт болон баримт бичгийн судалгааны арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон харьцуулалтын арга, учир шалтгааныг тайлбарлах, статистикийн үр дүнг хэрэглэх зэрэг аргыг хэрэглэв.

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа шинэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг судлах, шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийх, нотлох баримт цуглуулах аргад тулгуурлалаа. Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагыг хийх бүлгээ сонгохдоо анхан шатны нэгж дээр ажиллаж буй мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгчдөөс сонгож оролцуулав. Түүнчлэн судалгаанд иргэдийн үзэл бодлыг тусгах зорилтын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ийн хохирогчтой фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагуудыг хийлээ.

Судалгааны хүрээнд дүүргүүдийн Шүүхийн тамгын газар, шүүгч, хяналтын прокурор, цагдаагийн газар, гэр бүл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх хэлтэс болон мөрдөгч, гэмт хэргийн хохирогч, Монголын өмгөөлөгчдийн холбоо (МӨХ)-ны гишүүн өмгөөлөгч зэрэг нийт 50 хүнтэй 5 удаагийн фокус бүлгийн уулзалт хийлээ.

ЗУРАГ 1. ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА БОЛОН ФОКУС БҮЛГИЙН УУЛЗАЛТАД ОРОЛЦОГЧИД



Түүнчлэн Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн судалгаа, мэдээлэл сургалтын төв, Цагдаагийн ерөнхий газраас холбогдох мэдээллийг цуглууллаа. Шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхдээ Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс боловсруулсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”-ыг ашигласан болно.

Эдгээр арга зүй нь зорилтот бүлгийн хандлага, байр суурь, үүссэн нөхцөл байдал, үр дагавар, хууль эрх зүйн баримт бичиг болон судлаачдын үзэл баримтлалын нийцэл, амьдралд гарч буй тулгамдсан асуудал, шалтгаант холбоо зэргийг илүү нарийвчлан тодорхойлох, тоон үр дүнгээс илүү чанарын шинжилгээ хийхэд чиглэснийг дурдах нь зүйтэй. Судалгааны хүрээнд шүүхийн шийдвэрүүдийг шүүхээс болон бусад гэсэн үндсэн хоёр

хэлбэрээр цуглууллаа. Тухайлбал [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад байрлуулсан шүүхийн шийтгэх тогтоол, хяналтын шатны шүүхийн тогтоолоос шинэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн 58, хохирогчийн өмгөөлөгч нараас ажилласан хэргүүдийнх нь 9 шийтгэх тогтоолыг цуглуулж нийт 67 шийдвэрийг судаллаа. Үүнд:

- Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол – 53;
- Давж заалдах шатны шүүхийн магадлал – 5;
- Хяналтын шатны шүүхийн тогтоол – 9.

Сонгон авсан шинэ төрлийн 4 гэмт хэргийг эрх зүйн нэг бүлд хамаарах Бүгд Найрамдах Турк Улсын болон Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалттай харьцуулан судалсан болно. Эдгээр улсын эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх, хууль бусаар мөрдөж мөшгөх, ялгаварлан гадуурхах зэрэг гэмт хэргүүд нэршил томъёоллын хувьд Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан хэлбэрээс өөр байсан явдал нь харьцуулалт хийхэд тодорхой хэмжээний хүндрэл учруулав. Тухайлбал, бидний судалсан зарим гэмт хэрэг тухайн улсуудын Эрүүгийн хуульд бие даасан гэмт хэргийн хүрээнд хуульчлагдаагүй болохыг харж болох юм.

## **Нэг. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ (Эрүүгийн хуулийн 11.7)**

### **1.1. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх эрх зүйн зохицуулалт**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд Монгол Улсын иргэний дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. Үүнд:

- ...11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;
- ...13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэжээ.

Түүнчлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй” хэмээн суурь харилцааны үндсийг тодорхойлсон байна.

Манай улсын хувьд “гэр бүлийн хүчирхийлэл” хэмээх ойлголтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТХ)-иар төрөлжүүлэн зохицуулсан бөгөөд уг хуулийн 3 дугаар зүйлд<sup>2</sup> заасан этгээд мөн хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх

---

<sup>2</sup> Энэ хуулийн үйлчлэлд дараах этгээд хамаарна:

- эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;
- тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.
- Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна.

чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг ойлгодог.<sup>3</sup> Гэр бүлийн хүчирхийлэл нь дараах 4 хэлбэртэй байхаар хуульд<sup>4</sup> тусгасан байна. Үүнд:

- бие махбодын хүчирхийлэл;
- сэтгэл санааны хүчирхийлэл;
- эдийн засгийн хүчирхийлэл;
- бэлгийн хүчирхийлэл.

**Бие махбодын хүчирхийлэл** гэдэгт ГБХТХ-ийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг;<sup>5</sup>

**Сэтгэл санааны хүчирхийлэл** гэдэгт ГБХТХ-ийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг;<sup>6</sup>

**Эдийн засгийн хүчирхийлэл** гэдэгт ГБХТХ-ийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг;<sup>7</sup>

**Бэлгийн хүчирхийлэл** гэдэгт ГБХТХ-ийн 3 дугаар зүйлд заасан этгээд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг ойлгоно<sup>8</sup> гэж тус тус тодорхойлжээ.

<sup>3</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, 2016 оны 12 дугаар сарын 22, 5.1.1-р зүйл

<sup>4</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль 2016 оны 12.22, 6.1-р зүйл

<sup>5</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 оны 12 дугаар сарын 22, 6.2-р зүйл

<sup>6</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 оны 12 дугаар сарын 22, 6.3-р зүйл

<sup>7</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 оны 12 дугаар сарын 22, 6.4-р зүйл

<sup>8</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 оны 12 дугаар сарын 22, 6.5-р зүйл

ХҮСНЭГТ 1. ӨМНӨ МӨРДӨГДӨЖ БАЙСАН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ИЖИЛ  
ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

	2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
<b>Бүлэг</b>	<b>Арван тавдугаар бүлэг</b> Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	<b>Арван нэгдүгээр бүлэг</b> Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
<b>Зүйл</b>	<b>120<sup>1</sup>. Гэр бүлийн хүчирхийлэл</b> Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 120 <sup>2</sup> . Энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн, эсхүл асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн, эсхүл гэмт хэргийг таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	<b>11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх</b> 1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга: 1.1. зодсон; 1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; 1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг: 2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; 2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; 2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх хоёр хуулийн зүйл заалтыг харьцуулахад ногдуулах ял болон хамаарах бүлгийн нэр өөрчлөгдсөн байгаа нь харагдана. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуулиудаар зохицуулж байна.

## ХҮСНЭГТ 2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЗӨРЧИЛ БА ГЭМТ ХЭРГИЙН ЯЛГАА

### Зөрчлийн тухай хууль, 2017

ТАВДУГААР БҮЛЭГ  
НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

#### 5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

1. Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:
  - 4.1. зодсон;
  - 4.2. хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;
  - 4.3. бусадтай харилцахыг хязгаарласан;
  - 4.4. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

*Тайлбар: Энэ хуулийн тусгай ангид заасан "хууль зөрчих" гэж хууль, Захиргааны ерөнхий хууль, бусад хуульд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг ойлгоно.*

### Эрүүгийн хууль, 2015

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ  
ГЭМТ ХЭРЭГ

#### 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх

1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:
  - 1.1. зодсон;
  - 1.2. харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;
  - 1.3. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг:
  - 2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;
  - 2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;
  - 2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Бусад хууль, тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай зэрэг хуулиудад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах зохицуулалт, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлага нарийвчлан тусгагдсан.

## 1.2. Гэр бүлийн хүчирхийллийн холбоотой гэмт хэргийн талаарх Эрүүгийн эрх зүйн зохицуулалт

Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг болон харгалзан үзэх нөхцөлийг доорх байдлаар хуульчилжээ.

### ХҮСНЭГТ 3. ЭХ-Д ЗААСАН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД ХАРГАЛЗАХ НӨХЦӨЛ

Бие даасан гэмт хэрэг	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх <sup>9</sup>
Тусгай зүйлүүд	<ul style="list-style-type: none"> <li>- Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх<sup>10</sup>;</li> <li>- Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах<sup>11</sup>;</li> <li>- Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах<sup>12</sup>;</li> <li>- Заналхийлэх<sup>13</sup>;</li> <li>- Хууль бусаар мөрдөж мөшгөх<sup>14</sup>;</li> <li>- Хувь хүний нууцыг задруулах<sup>15</sup>.</li> </ul>
Зарим гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Хүнийг алах<sup>16</sup>;</li> <li>- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах<sup>17</sup>;</li> <li>- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах<sup>18</sup>;</li> <li>- Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах<sup>19</sup>;</li> <li>- Хүчиндэх<sup>20</sup>.</li> </ul>

<sup>9</sup> Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл

<sup>10</sup> Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйл

<sup>11</sup> Эрүүгийн хуулийн 10.2 дугаар зүйл

<sup>12</sup> Эрүүгийн хуулийн 11.2 дугаар зүйл

<sup>13</sup> Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйл

<sup>14</sup> Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйл

<sup>15</sup> Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйл

<sup>16</sup> Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.8

<sup>17</sup> Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.1

<sup>18</sup> Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2.1

<sup>19</sup> Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2.1

<sup>20</sup> Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.3



Бие даасан гэмт хэрэг	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх <sup>9</sup>
Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн<sup>21</sup>;</li> <li>- Байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор хохирогчид халдаж гэмт хэрэг үйлдсэн<sup>22</sup>;</li> </ul>
Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл	Аргагүй хамгаалалт <sup>23</sup> ; Албадлага, эрхшээлд автах <sup>24</sup> .

Хуулийн зохицуулалтаас үзвэл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийллийн доорх 5 үйлдэл л гэмт хэрэгт хамаарахаар байна. Үүнд:

1. зодсон;
2. харгис хэрцгий харьцсан;
3. догшин авирласан;
4. тарчлаасан;
5. хуваарьт болон дундын эд хөрөнгөө ашиглан зарцуулах эрхэд халдсан.

Эндээс эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэгт хамааруулсан нь оновчгүй юм.

Эрүүгийн эрх зүйн зохицуулалт талаас нь авч үзвэл, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1.1-д заасан гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэргийн ангилалд<sup>25</sup> хамаарах ба тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 1 жил<sup>26</sup>, харин 11.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 5 жил<sup>27</sup> байна.

Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т зааснаар анхан шатны шүүх нь шүүхийн шүүн таслах ажиллагааны практикт үндэслэн

<sup>21</sup> Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлийн 1.4

<sup>22</sup> Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлийн 1.7

<sup>23</sup> Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйл

<sup>24</sup> Эрүүгийн хуулийн 4.4 дүгээр зүйл

<sup>25</sup> Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

<sup>26</sup> Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг

<sup>27</sup> Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг

хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа Улсын дээд шүүх (УДШ)-д уламжлах, УДШ нь бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах,<sup>28</sup> уг тайлбараа тогтмол нийтлэх эрхтэй. Хуулийн энэ зохицуулалтын хүрээнд “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэсэн зүйлийг шүүхийн практикт хэрхэн ойлгож хэрэглэх талаар УДШ-ээс албан ёсны тайлбар одоогоор гараагүй байна.

#### ХҮСНЭГТ 4. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ БНТУ, МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ТУСГАГДСАН БАЙДАЛ

БНТУ-ын Эрүүгийн хууль	Монгол Улсын Эрүүгийн хууль
82.1/Д. зүйл Хүнийг санаатай алах гэмт хэргийг дээд ураг, доод ураг эсхүл эхнэр, нөхөр, ах дүүгийн эсрэг хийсэн бол хүндрүүлсэн тусгай зэрэглэлийн хорих ангид бүх насаар нь хорих ялаар шийтгэнэ.	10.1 дүгээр зүйл. Хүнийг алах 2.8. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж... хүнийг алсан бол арван хоёроос хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.
86.3/А. зүйл Санаатай гэмтэл учруулах гэмт хэргийг дээд ураг, доод ураг эсхүл эхнэр, нөхөр, ах дүүгийн эсрэг хийсэн бол 2-4 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.	11.1 дүгээр зүйлийн 2.1. гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан бол 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 11.4 дүгээр зүйлийн 2.1. гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан бол 2700-14000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 11.6 дугаар зүйлийн 2. гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол 450-2700 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн зохицуулалтыг Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ)-ын Эрүүгийн хуультай харьцуулбал, БНТУ-ын Эрүүгийн хуульд гэр бүлийн

<sup>28</sup> Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1

хүчирхийллийг тусдаа бие даасан гэмт хэрэг гэж авч үзээгүй боловч Хүнийг санаатай алах (82.1/Д), Санаатай гэмтэл учруулах (86.3/А) зэрэг гэмт хэргүүдэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх замаар дээрх гэмт хэргийг төгсгөсөн тохиолдолд оногдуулах ялыг хүндрүүлэх байдлаар хуульчилжээ.

Дээрх хуулийн харьцуулалтаас үзвэл, БНТУ-ын Эрүүгийн хуульд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг санаатай алсан тохиолдолд зөвхөн бүх насаар нь хорихоор хатуу хуульчилсан бол Монгол Улсын Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг санаатай алсан тохиолдолд оногдуулах ялын доод хэмжээг 12 жил, дээд хэмжээг бүх насаар нь хорихоор тогтоожээ. БНТУ-ын хуульд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний биед гэмтэл учруулсан бол 2-4 жил хорих ял оногдуулахаар хуульчилсан бол Монгол Улсын Эрүүгийн хуульд хохирогчийн эрүүл мэндэд учирсан гэмтлийн зэргээс хамааралтайгаар шүүхээс гэмт хэрэгтэнд оногдуулах ялын төрөл, хэмжээг сонгож болохоор тогтоосон.

Товч дүгнэвэл, БНТУ-ын Эрүүгийн хуулийн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зохицуулалт нь сонгох санкцгүй, зөвхөн хорих ялтай байгаа бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн хариуцлага нь илүү уян хатан, ялын хувьд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих гэх зэрэг сонголттой байна.

### 1.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нөхцөл байдал

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын мэдээлснээр дэлхий даяар өмнөх 12 сарын хугацаанд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр болон хамтрагчийн зүгээс бэлгийн ба бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.<sup>29</sup>

Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн шүүн таслах ажиллагааны тайланд, Цагдаагийн ерөнхий газар сар тутам гаргадаг гэмт хэргийн статистик мэдээндээ тусгаж олон нийтэд нээлттэй, ил тодоор хүргэдэг. Мөн Үндэсний статистикийн хорооноос жил бүр гэмт хэргийн судалгаа, мэдээллийг нэгтгэн дэлгэрэнгүй тайланг гаргаж байна. 2016 оноос эхлэн Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан номд гэр бүлийн

<sup>29</sup> Статистикийн тойм, "Гэр бүлийн хүчирхийлэл", Улаанбаатар хот, 2020 он, [https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GBHuchirhiilel\\_2020q1.pdf&ln=Mn](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GBHuchirhiilel_2020q1.pdf&ln=Mn)

хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, нөхцөлийн талаар тодорхой судалгааг тусгах болжээ.

2017 оны 7 дугаар сарын 1-ээс 2020 оны хооронд Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай анги (ЭХТА)-ийн 11.7 дугаар зүйлд заасан “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” 751 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ.<sup>30</sup> Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн статистикаас үзвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг жил дараалан буурсан үзүүлэлттэй байна.<sup>31</sup>

#### ХҮСНЭГТ 5. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭГДСЭН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ НИЙТ ГЭМТ ХЭРЭГ

2017 он	2018 он	2019 он	2020 он	Бүгд
223	210	207	111	751

Харин ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсээс гаргасан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн нарийвчилсан статистик мэдээгээр 2019 онд гэр бүлийн хүчирхийллийн холбоотой 985 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2020 онд 1,138 болж өмнөх оноос 153 хэргээр буюу 15.5 хувиар өсөж, бүх хэрэгт эзлэх хувийн жин 4.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.8 нэгжээр өсжээ.<sup>32</sup>

Гэр бүлийн хүрээнд хүний эрүүл мэндийн эсрэг болон хүчиндэх гэмт хэргүүд өсжээ. Тухайлбал, 2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 18 хүн амиа алдаж, 953 хүн гэмтэж, иргэдэд 928.3 сая төгрөгийн хохирол учирсан байна. Үүнийг өмнөх онтой харьцуулбал нас барсан хүн 2.3 дахин, гэмтсэн хүн 30.2 хувь, учирсан хохирол 54.7 хувиар өсжээ.<sup>33</sup>

Анхан шатны шүүхүүд 2017-2020 онд ЭХТА-ийн 11.7 дугаар зүйл “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргээр 2017 онд 59, 2018 онд 115, 2019 онд 210, 2020 онд 101, нийт 485 хэрэг шийдвэрлэсэн байна.

<sup>30</sup> ЦЕГ-ын статистик мэдээ

<sup>31</sup> ЦЕГ-ын статистик мэдээ, 2017-2020 он

<sup>32</sup> Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн хуралд тавьсан илтгэл, ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн дарга Баярбаясгалан, 2021 оны 3 дугаар сарын 4

<sup>33</sup> Мөн тэнд

ХҮСНЭГТ 6. 2019-2020 ОНД ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭРЭГ<sup>34</sup>

Гэмт хэрэг	Гэмт хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо				Хорих ял оногдуулагчгүйгээр тэнсэх
	2019 он	2020 он	тоо	Хувь	2019 он	2020 он	тоо	Хувь	
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	210	101	-109	-51.9	176	67	-109	-61.9	31

2018 онд 115 хэрэгт 73 хүн шүүхээр шийтгүүлсэн бол 2019 онд 210 хэрэгт 176 хүн шийтгүүлж өмнөх оноос 2.4 дахин өссөн, 2020 онд шүүхүүд ГБХ-ийн 101 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх оноос 109 хэргээр буюу 51.9 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

ХҮСНЭГТ 7. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮН

Утга	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	Хувь
ГБХ-д өртсөн хүн бүгд	1193	1552	359	30.1
Үүнээс Эмэгтэй	1022	1255	233	22.8
Өсвөр насны хүн	90	141	233	22.8

Шүүн таслах ажиллагааны мэдээнд тусгагдсанаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн 2019 онд 1,193 байсан бол 2020 онд 1,552 болж 359 хүн буюу 30.1 хувиар өсжээ. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хүний тоо 61.9 хувиар буурсан<sup>35</sup> байна.

Шүүх, цагдаагийн байгууллагын статистик мэдээллийн санд бүртгэгдсэн ЭХТА-ийн 11.7 дугаар зүйл буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо нь гэр бүлийн хүчирхийллийн цар хүрээг бүрэн илэрхийлэхгүй байна. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг алах, амиа хорлоход хүргэх, хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулах гэмт хэргүүдийн тоог 11.7 дугаар зүйлээр бүртгэгдсэн хэргүүд дээр нэмж байж хуулийн байгууллагад бүртгэгдсэн, шийдвэрлэгдсэн хэргийн хүрээг тодорхойлж болох юм.

<sup>34</sup> Монгол Улсын шүүхийн 2019 оны тайлан 221 дүгээр тал, [https://judcouncil.mn/site/site/news\\_full/10084](https://judcouncil.mn/site/site/news_full/10084)

<sup>35</sup> Монгол Улсын шүүхийн 2020 оны шүүн таслах ажиллагааны мэдээ

#### 1.4. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал

Хэрэг бүртгэгч, мөрдөгч нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагын явцад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэргийг мөрдөх явцад хамгийн нийтлэг тохиолддог бэрхшээл нь хохирогч гомдлоосоо татгалзах, анх өгсөн мэдүүлгээсээ буцах, гэр бүлийн хүчирхийллийг “байнга” үйлдсэн гэдгийг нотлоход төвөгтэй зэрэг шалтгааныг дурджээ.

1. Байнга гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд л эрүүгийн хэрэг үүсгэх ёстой. Хэрэг үүсгэх гэхээр хүчирхийлэл үйлдэгч өмнө нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авхуулчихсан байдаг. Гэтэл Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээсэн бол “байнга” гэдэгт хамаарахгүй гээд УДШ тайлбарлачихсан учир ихэнх нь эрүүгийн хэрэг болдоггүй.
2. Хохирогч өмнө нь хуулийн байгууллагад хандаагүй бол нотлох баримт олоход хэцүү. Ер нь хохирогчийн мэдүүлгээс өөр баримт гарч ирэхгүй байгаа учир хэрэг үүсгэхээс татгалзахаас өөр аргагүй болдог. Нэг бол хэдэн сар, жилийн өмнө зодсон байдаг. Тэдгээр үйлдлүүдийн хоорондох хөөн хэлэлцэх хугацаа нь дуусчихсан байх жишээний.
3. Одоогийн практикт бол шүүх эмнэлэгт үзүүлээд гэмтлийн зэрэг тогтоогдсон тохиолдолд тэр зүйл ангиар нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.
4. Хүндрэлтэй зүйл бол хохирогч гомдолгүй, өргөдлөө буцаая гэсэн асуудал их тавьдаг.
5. Дуудлагаар очиход эхнэр нөхөр хоёулаа харилцан зодолдох явцдаа нэг нь нөгөөдөө гэмтэл учруулсан тохиолдол гарсан. Хоёуланд нь эрүүгийн хэрэг үүсгээд шүүхээр оруулсан.

Мөрдөгч нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэлээс

Хэдийгээр гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар очсон цагдаагийн алба хаагч нар “аюулын зэргийн үнэлгээ” хийж байгаа ч түүнийг нотлох баримтаар хэрэгт хавсаргасан тохиолдол байхгүй байв. Ярилцлагад оролцсон хэрэг бүртгэгч, мөрдөгч нарын хувьд гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, бусад гэмт хэргээс ялгагдах онцлог, хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн сэтгэл зүйн онцлог, аюулгүй байдлын асуудлуудтай холбоотой мэдлэг, амьдралын түүхэнд суурилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах үр чадвар дутмаг байгаа нь ажиглагдав.

Харин хохирогч нарын хувьд хүчирхийлэл үйлдэгч дахин ийм үйлдэл хийхгүй гэж амласан, гомдлоо буцаахыг ятгасан, айлгаж сүрдүүлсэн,

хоорондоо эвлэрсэн, гэр бүлийн эдийн засаг хэцүүдэх, салахаас айсан гэх зэрэг шалтгаанаар гомдлоо буцаах хүсэлт гаргасан байна.

Би нөхөртөө зодуулаад хуулийн байгууллагад хандсан. Хэрэг хийсэн хүн шиг л цагдаа дээр байн байн дуудагдаад ажлаа ч хийхэд хэцүү юм байна. Нөгөө талаар хадмууд нөхрөө шоронд явуулах гэлээ гэж загнаад болохгүй болохоор би гомдолгүй, цааш шалгуулахгүй гээд бичээд өгчихсөн. Прокуророос хэрэг үүсгэхээс татгалзсан хариу ирсэн.

Хохирогчтой хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс

2017-2020 онд цагдаагийн байгууллагад ГБХ-ийн 751 хэрэг бүртгэгдсэнээс 485 нь буюу бүртгэгдсэн хэргийн 64.6 хувь нь шүүхээр шийдвэрлэгджээ. Монголын криминологичдын холбооноос хийсэн судалгаагаар гэмт хэргийн шинжгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр ГБХ-ийн нийт хэргийн 34 хувийг хэрэгсэхгүй болгосон байна.<sup>36</sup>

Бидний судалсан ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх)-т заасан 9 хэргээс гурвыг нь анхан шатны шүүх хэрэгсэхгүй болгож, цагаатгажээ. Хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг авч үзвэл:

- Хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр - 1 хэрэг;
- Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээсэн тул давхардуулж эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй гэсэн үндэслэлээр 2 хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Үлдсэн 6 хэргийн шүүгдэгчид 6 сараас 1 жил 6 сарын хорих ял оногдуулж, ялыг нээлттэй хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

УДШ-ээр хянагдсан 9 хэргийн хувьд, 2 хэргийн шүүгдэгчид хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон, 3 хэргийг анхан шатны шүүхээс хэрэгсэхгүй болгосон шийтгэх тогтоолыг хэвээр баталсан, 1 хэрэгт анхан шатны шүүхээс оногдуулсан хорих ялыг хөнгөрүүлж шийдвэрлэжээ. Харин 1 хэргийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт буцаасан байна.

<sup>36</sup> “Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь” судалгааны тайлан, Монголын Криминологичдын холбоо, 2020 он

■ Зүйлчлэлтэй холбоотой асуудал

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нэг онцлог шинж нь тухайн зүйлд заасан үйлдлийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг байнга үйлдсэн тохиолдолд хамаарахаар хуульчилсан.

Гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдэд гэмтлийн зэрэг тогтоогдсон тохиолдолд ихэвчлэн ЭХТА-ийн 11 дүгээр бүлгийн өөр зүйлүүд (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хөнгөн, хүнд, хүндэвтэр хохирол учруулах)-ээр шийдвэрлэгдэж байна.

Хохирогчийн биед хөнгөн, хүнд гэмтэл учирсан байхад 11.7 (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх)-оор зүйлчилсэн хоёр тохиолдол гарснаас үзэхэд хууль хэрэглээний асуудлыг цаашид нэг мөр болгохгүй бол гэмт этгээдийг өөгшүүлэх сул талтай. 11.7 дугаар зүйлийн 1.1 (зодох), 1.2 (харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах), 1.3 (хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах)-т заасан үйлдлүүд давхацсан байхад давхар зүйлчилж шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн биед гэмтэл учирсан нь шүүх эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдсэн байсан ч ЭХ-ийн 11 дүгээр бүлгийн 11.1 (Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах), 11.4 (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах), 11.6 (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах) гэх мэт зүйлүүдийн хүндрүүлэх нөхцөлд хамааруулан зүйлчилж шийдвэрлэдэг практик тогтжээ.

Энэ талаар УДШ “Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нэг харилцаа буюу хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд халдаж хохирол учруулсан нэг үйлдлийг тухайн харилцааны доторх өөр зүйл, хэсгээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэсэн шударга ёсны зарчимд нийцэхгүй тул нэг үйлдлийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж бусдын биед гэмтэл учруулсан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг гэж салгаж зүйлчлэх боломжгүй” гэж тайлбарласан байна.



### ■ Нотлох баримт

Нотлох баримтын хувьд хэргийн газрын үзлэг, хохирогчийн мэдүүлэг, нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээ, шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлгийг үндэслэн хэргийг шийдвэрлэжээ. Судалгаанд хамрагдсан гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдэд хохирогч иргэний нэхэмжлэл гаргасан, түүнийг шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байна.

### ■ Шүүхээс гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага

ЭХ-ийн 11.7 дугаар зүйлд зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих, харин хүндрүүлэх нөхцөлтэй гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл мөн хугацаагаар хорих ял шийтгэх зохицуулалттай. Шүүх 2019 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 176 хүнээс 47-д, 2020 онд 67 хүнээс 31-д нь хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн байна<sup>37</sup>. Бусдад нь зургаан сараас нэг жил хүртэлх хорих ял оногдуулжээ.

ЭХ-ийн Ерөнхий ангийн 7.2 дугаар зүйлд шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нь нэмж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ болон хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хүлээлгэж болохоор заасан. Мөн хуулийн 7.3 дугаар зүйлд шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалт тогтоож болно гэж заасан. Тиймээс гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж буй эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх үүргийг хүлээлгэж болох юм. Түүнчлэн тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт

<sup>37</sup> Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйл: “хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан... бол гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно”.

зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг хязгаарлалт тогтоох, шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүхээс ял оногдуулах зохицуулалттай.

Энэхүү албадлагын арга хэмжээ нь гэр бүлийн хүчирхийллийн хэрэг үйлдсэн хүнд хэрэглэхэд тохиромжтой, хохирогчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Гэвч судалсан шийдвэрүүд дотор гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхдээ үүрэг хүлээлгэх болон хязгаарлалт тогтоох албадлагын арга хэмжээ авсан тохиолдол байхгүй байв. Иймд цаашид Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтыг ГБХ-ийн хэргийг шийдвэрлэх шүүхийн практикт нэвтрүүлэхэд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Шүүхийн шийтгэх тогтоолуудад дүн шинжилгээ хийх явцад:

- Мөрдөн байцаалтын ажиллагааг дутуу хийх;
- Прокурор яллах дүгнэлт үйлдэхдээ яллагдагчийн холбогдсон хэргийн агуулгыг хэт ерөнхий байдлаар товч бичиж яллагдагч хэзээ, хаана, хэний эсрэг, хэдэн удаа, ямар арга, хэлбэрээр ГБХ үйлдсэн, бусдад ямар хохирол учирсан, уг хэргийг хүндрүүлэх ямар шинж тогтоогдсон талаар дурдахгүй байх;
- Анхан шатны шүүх прокурорын яллах дүгнэлтэд огт дурдаагүй хэргийн үйл баримтыг шийтгэх тогтоолд бичиж, ЭХХШТХ-ийн 34.14 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаарыг ноцтой зөрчиж байгаа нь илэрсэн.

Шүүхүүд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэргийг шийдвэрлэхдээ УДШ-ээс тодорхой хэргийг хянан шийдвэрлэх явцдаа гаргасан 2019 оны 506, 572, 630, 633, 2020 оны 202, 334 дүгээр тогтоолуудыг хэрэглэж байна. Гэвч эдгээр тогтоол нь өөр хоорондоо зөрчилтэй тул шүүхийн практикт хэрэглэхэд хүндрэл учруулдаг ажээ. Тухайлбал:

...Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан “байнга” гэх шинж нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирлаж тарчлаасан зэрэг үйлдлийг тооны хувьд 3 ба түүнээс дээш удаа үйлдсэнийг ойлгох бөгөөд энэхүү үйлдэл нь зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй эсэх нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй болно;<sup>38</sup>

<sup>38</sup> УДШ-ийн 2020 оны 6 дугаар сарын 22-ны 334 дүгээр тогтоол

...Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;<sup>39</sup>

...Зөрчилд шийтгүүлсэн ...нэг удаагийн тохиолдол ...нь дангаараа гэмт хэргийн шинжийг хангаж чадахгүй ч өөр бусад ижил тохиолдолтой нэгдэж гэмт хэргийн шинжийг хангаж байгаа тохиолдолд зөрчилдөө шийтгүүлсэн нь хууль бус үйлдлийн цаана хамгаалагдаж буй харилцааг Эрүүгийн хуулиар хамгаалах зорилгыг хязгаарлах үндэслэл болохгүй;<sup>40</sup>

...Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу хариуцлага хүлээгээгүй, гэр бүлийн хамааралтай байдлыг нь далимдуулан зодсон гурав ба түүнээс дээш удаагийн бие даасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан шинжийг хангана<sup>41</sup> гэхчлэн өөр өөрөөр тайлбарласнаас үзвэл өмнө нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэсэн хүнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах, хариуцлага хүлээлгэх эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байна.

Хор уршгийн хувьд ч мөн харилцан адилгүй тайлбарлажээ. Тухайлбал, УДШ-ийн 2019 оны өдрийн 506 дугаар тогтоолд "...Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан өөр гэмт хэргийн шинжийг агуулаагүй, хохирол, хор уршиг учраагүй...байхыг ойлгоно<sup>42</sup>" гэж тайлбарласан бол мөн УДШ-ийн 2019 оны 633 дугаар тогтоолд "ГБХ-ийн шинжтэй үйлдэл нь ямар тохиолдолд гэмт хэрэгт тооцогдохыг ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан... үйлдэл нь байнгын шинжтэй" гэж хуульчилж тогтоосон бөгөөд дээрх үйлдлийн улмаас ямар нэгэн хохирол, гэмтэл учирсан байхыг шаарддаг"<sup>43</sup> хэмээн тайлбарласан нь хоорондоо зөрүүтэй төдийгүй Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн зохицуулалттай нийцэхгүй байна.

<sup>39</sup> УДШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 633 дугаар тогтоол

<sup>40</sup> УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 27-ны 202 дугаар тогтоол

<sup>41</sup> УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 506 дугаар тогтоол

<sup>42</sup> УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 506 дугаар тогтоол

<sup>43</sup> УДШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 633 дугаар тогтоол

### ТОХИОЛДОЛ 1.

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Л.Э-г гэр бүлийн харилцаатай хүнтэй байнга догшин авирласан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар 6 сарын хугацаатай хорих ял шийтгэж, уг хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн.<sup>44</sup>

Улсын дээд шүүх: Шүүгдэгч Л.Э-ийн 4 удаа Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шийтгүүлсэн нөхцөл байдал нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан гэмт хэргийн шинжийг хангахгүй байх тул анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэн Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 601 дүгээр шийтгэх тогтоол, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 562 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, Л.Э-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан гэмт хэргийг хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасан.

УДШ үндэслэлээ тайлбарлахдаа: Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчлийн бүрэлдэхүүний объектив талын үндсэн шинж нь “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн”-ийг зодсон; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэсэн 4 шинжийн аль нэг нь эсхүл хэд хэд нь тогтоогдож байгаа тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ. Гэтэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн объектив талын үндсэн шинж нь “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн”-ийг байнга зодсон; харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэсэн 3 шинжийн аль нэгийг эсхүл хэд хэдэн шинжийг тус бүр байнга үйлдсэн байхыг шаардсан байх бөгөөд Л.Э-ийн шийтгүүлсэн зөрчлөөс В.О-г “зодсон”, “хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхэд нь халдсан” гэсэн 2 зөрчлөөс бусад нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжид хамаарахгүй байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний “байнга” гэсэн шинжийг хангахад дээрх хоёр хуулийн ижил шинжүүдээс давтагдаж буй шинжүүдээр дүгнэлт хийх хүрээгээ тогтоож байх нь зөрчил ямар тохиолдолд гэмт хэрэгт шилжиж байгааг тодорхойлох хууль зүйн үндэслэл болно” гэжээ.

<sup>44</sup> Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 601 дүгээр шийтгэх тогтоол

Түүнчлэн УДШ 11.7 дугаар зүйлийг Эрүүгийн хуулийн зохицуулалтаас өргөн хүрээнд ойлгож хэрэглэхээр тайлбарлажээ. Тухайлбал, УДШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 630 дугаар тогтоолд “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн зэрэг хүчирхийллийн аль нэгийг байнгын шинжтэй үйлдсэн тохиолдолд дээрх гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдэнэ”<sup>45</sup>, “...Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив тал буюу гадаад илрэх шинж нь хохирогчийг бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн хүчирхийлэлд оруулах, зодох, харгис хэрцгий харьцах, догшин авирлах, тарчлаах, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах үйлдлээр тодорхойлогдох бөгөөд...” гэж тус тус заасан.

Тохиолдол 1-ээс дүгнэвэл, Эрүүгийн хуульд заасан гэр бүлийн хүчирхийллийн үйлдлүүдийг бүгдийг нь Зөрчлийн тухай хуульд тусгаж өгч байж 11.7-д заасан “байнга” гэсэн шинж хангагдахаар байна. УДШ-ийн тайлбарууд нь доорх эргэлзээ, ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Үүнд:

1. “Байнга” гэдэг ойлголтын агуулга;
2. Зөрчлийн үйлдлийг гэр бүлийн хүчирхийллийн давтамжийн тоонд хамааруулах эсэх;
3. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг үндэслэж эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэх;
4. ГБХ-ийн хэрэгт хохирол, хор уршиг шаардах эсэх;
5. ГБХ-ийн ямар үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх;
6. 11.7 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэх эсэх.

## 1.5. Фокус бүлгийн ярилцлага

Фокус бүлгийн ярилцлагыг мөрдөгч, өмгөөлөгч, шүүгч, прокурор, хохирогчдын дунд явууллаа. Фокус бүлгийн ярилцлагын явцад Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийг хэрэглэхэд тулгамдаж буй доорх асуудлууд хөндөгдсөн. Үүнд:

---

45 УДШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн №630 тогтоол

- ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид өөр өөрөөр ойлгон хэрэглэж байна. Уг зүйлийн “байнга” үйлдэх гэдгийг хэрхэн ойлгох талаар УДШ-ийн албан ёсны тайлбар байхгүй. Гэр бүлийн хүчирхийллийн тодорхой хэргийг хянан шийдвэрлэсэн УДШ-ийн тогтоолууд өөр хоорондоо зөрүүтэй, бие биеэ үгүйсгэсэн шинжтэй. ЭХ-ийн 11.7 дугаар зүйлийн хэсэг бүрт заасан үйлдлийг “байнга” хийсэн нөхцөлд л эрүүгийн хэрэгт тооцохоор байгаа нь гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учруулж байна.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн этгээд өмнө нь тэдгээр үйлдэлдээ Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээгээгүй байх, 11.7 дугаар зүйлд заасан үйлдэл тус бүрийн давтамжийн хоорондох хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх зэрэг нөхцөлүүд хангагддаггүй учир хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болоход нөлөөлдөг.
- Гэр бүлийн хүчирхийллийг “Байнга” үйлдсэн гэдгийг хэрхэн ойлгох, 11.7 дугаар зүйлд заасан үйлдлүүдийн давтамжийн хоорондох хөөн хэлэлцэх хугацаа нь ямар байх талаар тогтсон нэг ойлголт байхгүй байна. Зөрчлийн тухай хуулийн 6 сарын хөөн хэлэлцэх хугацааг мөрдөх үү, эсхүл Эрүүгийн хуулийн 1 жилийн хөөн хэлэлцэх хугацааг мөрдөх үү гэдгийг нэг мөр болгох шаардлагатай.
- Өмнө нь Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдсэн эсэхээс үл хамааран 3 буюу түүнээс дээш удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол гэмт хэрэгт тооцож шийдвэрлэж байсан. Одоогийн практикт нэг хэрэгт давхардуулан шийтгэл оногдуулж байна гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болж байгааг анхаарах шаардлагатай.
- Хуваарьт болон дундын өмч хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд байнга халдсан бол Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Энэ нь хууль тогтоогч уг эд хөрөнгийн үнийн дүн, тухайн эд хөрөнгө хохирогчийн ахуй амьжиргаанд ямар үүрэгтэйг харгалзан үзээгүй. Жишээ нь, дундын өмч хөрөнгө болох цорын ганц орон байраа зарснаас болж тухайн гэр бүл хэвийн амьдрах нөхцөл боломжгүй болж болно. Гэтэл тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэхийн тулд дахиад ямар нэг эд хөрөнгөө зарах, бусдын нэр дээр шилжүүлэх хүртэл нь хүлээх шаардлага тавигдаж байгаа нь хохирогчид илүү эрсдэлийг үүсгэж байна.

- ГБХТХ-д гэр бүлийн хүчирхийллийн 4 хэлбэр (сэтгэл санааны, бие махбодын, эдийн засгийн, бэлгийн)-ийг зааж өгсөн атлаа Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд зарим үйлдлийг нь салгаж зөрчил, гэмт хэрэг гэж заасан бөгөөд бусад үйлдэл нь гэмт хэрэг ч биш, зөрчил ч биш болж байна. Сэтгэл санааны хүчирхийллийг ГБХТХ-д заасан хэлбэрээр тодорхойлох нь зөв ч үйлдлийг нэг бүрчлэн тоочиж дурдахаар тоочигдоогүй үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн аль нь ч биш болчихоод байгааг анхаарах ёстой.
- “Тарчлаах”, “харгис хэрцгий харьцах” гэх мэт зарим үйлдлийн хувьд эдгээр үйлдлийг байнга, давтан үйлдсэн байхыг шаардахгүй гэж ЭХ-д тусгах нь зүйтэй. Тарчлаах л гэхэд “байнга” гэсэн шинжийг өөртөө агуулдаг.
- 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн этгээдэд зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь уг гэмт хэргийн онцлог, “байнга” үйлдсэн гэх шинжид тохирохгүй, ялын бодлого хөнгөн байна.
- Зөрчлийн тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж, 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулдаг. Баривчлах шийтгэлийг тэнсэх тухай ойлголт байхгүй учир шийтгэлээ биечлэн эдэлж байна. Гэтэл гэр бүлийн хүчирхийллийг “байнга” үйлдсэн эрүүгийн хэрэгт хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх боломжтой байгаа нь давтагдаж даамжирсан үйлдэлд хариуцлагын үр нөлөөг бууруулж, гэмт этгээдэд ял завших боломж олгосон.

## 1.6. Бүлгийн дүгнэлт

Анхан шатны шүүхүүд 2017 оноос 2020 оны 1-р улирлыг дуусталх хугацаанд ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 474 хэргийг шийдвэрлэсэн бөгөөд шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо жил тутам өссөн үзүүлэлттэй байна. Гэвч “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” хэргүүдийн 34 хувийг “гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй”, “хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон нь хүчирхийлэл үйлдэгчдэд ял завшуулж, хохирогчийг улам эрсдэлд оруулж байна.

Энэ төрлийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгоход нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийллийг “байнга” үйлдсэн байх шинжийг хуульчилсантай холбоотой. Нөгөө талаар өмнө нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдэж байсан бол “байнга” гэсэн шинжид хамааруулахгүй байхаар тодорхой хэргийг хянан шийдвэрлэх явцад гаргасан УДШ-ийн тайлбарыг практикт хэрэглэж байгаа нь нөлөөлж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар Улсын Дээд шүүх нь Үндсэн хуулиас бусад хуульд албан ёсны тайлбар гаргах эрхтэй ч одоогоор Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийг практикт хэрхэн ойлгож хэрэглэх талаарх албан ёсны тайлбар гараагүй байгаагаас “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар нэгдсэн ойлголт байхгүй.

Шүүгчид УДШ-ээс тодорхой хэргийг шийдвэрлэх явцдаа тайлбарласан өөр хоорондоо зөрчилдөөнтэй, нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн харилцан адилгүй тайлбарыг хэрэглэж байна. Уг тайлбарууд нь зөрчлийн үйлдлийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн давтамжийн тоонд хамааруулах эсэх, ГБХ-ийн хэрэгт хор уршиг шаардах эсэх, хөөн хэлэлцэх хугацаанд аль хуулийн зохицуулалтыг баримтлах эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байгаа тул шүүхийн практикт хэрэглэхэд хүндрэл учруулж байна.

Хохирогчийн биед гэмтэл учирсан байхад ЭХТА-ийн 11 дүгээр бүлгийн тухайн зүйл ангиар биш, 11.7 дугаар зүйлээр зүйлчилж шийдвэрлэх, гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдэж, хохирогчийн биед гэмтэл учруулсан байхад давхар зүйлчлэхгүй, зөвхөн гэмтэл учруулсанд нь эрүүгийн хэрэг үүсгэж хариуцлага хүлээлгэх, 11.7 дугаар зүйлийн өөр өөр хэсэгт заасан тарчлаах, эд хөрөнгө эзэмших, захиран зарцуулах эрхэд халдах гэх мэт үйлдлийг байнга хийсэн байхад давхар зүйлчлэхгүй орхих зэрэг хууль хэрэглээний алдаа гарчээ.

Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нарын гэр бүлийн хүчирхийлэл, түүний бусад төрлийн гэмт хэргээс ялгагдах онцлог, хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн хоорондын харилцаа, хамаарал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зайлшгүй тодруулах үйл баримт, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зэрэг энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд нэн шаардлагатай ойлголт, мэдлэг хангалтгүй.



ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэгт хамааруулсан нь оновчгүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн тохиолдолд зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж, 7-30 хоног баривчлах зохицуулалттай. Гэтэл Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл “байнга” үйлдсэн тохиолдолд ял оногдуулахгүй тэнсэх боломжтой байгаа нь байнга зодох, харгис хэрцгий харьцах, тарчлаах, догшин авирлах зэрэг хор уршиг ихтэй үйлдэлд Зөрчлийн тухай хуулиас хөнгөн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Шүүхээс шүүгдэгчид хорих ял оногдуулж байгаа ч зан үйлээ засах сургалтад хамрагдахыг үүрэг болгох гэх мэт албадлагын арга хэмжээ хэрэглэсэн тохиолдол байхгүй байна.

## **Хоёр. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА БАЙДАЛ (Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйл)**

Манай улс Үндсэн хуульдаа “Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасан.<sup>46</sup> Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” хэмээн тунхагласан билээ.<sup>47</sup>

Ийнхүү манай улс олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, Үндсэн хуулиараа баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд нөхөн сэргээх хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргээ биелүүлэхэд чухал ач холбогдолтой хуулийн нэг нь Эрүүгийн хууль юм. 2002 оны Эрүүгийн хуульд гагцхүү бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх үйлдэлд л эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан. Гэвч хувийн халдашгүй чөлөөтэй байх эрх болон бусад эрхэд заналхийлэл, сүрдүүлэгд өртөх нөхцөл байдал тодорхой түвшинд илрэн гарах болсонтой холбогдуулан 2015 оны Эрүүгийн хуульд шинэ төрлийн гэмт хэргийг тусгасан.

Цагдаагийн байгууллагын статистик мэдээнд 2017 оноос 2020 оны эхний 11 сарын хугацаанд нийт 163 “Заналхийлэх” гэмт хэрэг бүртгэгджээ. Он тус бүрээр авч үзвэл, 2017 онд 18, 2018 онд 56, 2019 онд 56, 2020 оны эхний 11 сард 33 хэрэг тус тус бүртгэгджээ.

---

<sup>46</sup> Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, 2 дугаар бүлэг.

<sup>47</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 оны 12 дугаар сарын 10, 1,2 дугаар зүйл

## 2.1. Эрүүгийн хуулийн зохицуулалт

### 13.5 ДУГААР ЗҮЙЛ. ЗАНАЛХИЙЛЭХ

Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ (*Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*).

#### 2. Энэ гэмт хэргийг:

2.1. бүлэглэж;

2.2. зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (*Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан*).

#### 3. Энэ гэмт хэргийг:

3.1. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж;

3.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### Нэр томьёо:

*Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардах* гэж гэмт этгээдээс тухайн хүн эсхүл ойр дотнын хүнээр нь өөрийн хүсэл сонирхолд нийцсэн үйлдэл хийлгүүлэхийг албадсан, эсхүл хийх ёстой зүйлийг нь татгалзуулах зорилго бүхий хууль бус аливаа үйлдлийг ойлгоно.<sup>48</sup>

*Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлэх* гэж хохирогчийн бие махбодод халдах, эрүүл мэндэд нь хохирол учруулах, зорчих эрхийг хязгаарлах, хоол

<sup>48</sup> С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг”, 2018 он, 85-р тал.

унд, нойргүй удаан хугацаагаар эрхшээлдээ байлгах, өөрийг нь болон ойр дотнын хүнийг ална, эрүүл мэндэд хохирол учруулна, эрх, эрх чөлөөг нь хязгаарлана зэргээр айлган сүрдүүлсэн байхыг ойлгоно.<sup>49</sup>

*Эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл* гэж тухайн хүнд олгосон эрх, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй агуулгатай мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.<sup>50</sup>

*Тараахаар сүрдүүлсэн* гэж дээр дурдсан мэдээллийг олон нийтэд, эсхүл ач холбогдол бүхий бусад хүмүүст шилжүүлэх, танилцуулахаар заналхийлснийг ойлгоно.<sup>51</sup>

ЭХ-ийн 13.5 дугаар зүйлд заасан Заналхийлэх гэмт хэрэг нь “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийн бүлэгт багтах бөгөөд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна. Гэмт хэргийн бүрэлдэхүүний 4 тал онолоор авч үзвэл:

*Объект:* Хүний хувийн эрх чөлөө, халдашгүй, чөлөөтэй байх эрх.

*Объектив тал:* Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн идэвхтэй үйлдэл байна.<sup>52</sup>

*Субъект:* Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, хувь хүн байна. Хүндрүүлэх шинжид заасан гэмт хэргийн тухайд эрх бүхий албан тушаалтан байна.

*Субъектив тал:* Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байна. Хувийн өс хонзонгийн сэдэлтээр үйлдэгддэг. Эд хөрөнгө авах, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хувьд заналхийлсэн бол энэ нь гэмт хэрэг болохгүй.<sup>53</sup>

<sup>49</sup> С.Гантулга, Б.Энхболд. дурдсан бүтээл. 2018 он, 85-р тал.

<sup>50</sup> Мөн тэнд.

<sup>51</sup> Мөн тэнд.

<sup>52</sup> С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг”, 2018 он, 84-р тал.

<sup>53</sup> С.Гантулга, Б.Энхболд дээр дурдсан бүтээл. 2018 он, 85-р тал.

ХҮСНЭГТ 8. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ӨМНӨ МӨРДӨГДӨЖ БАЙСАН  
ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ОЙРОЛЦОО ТӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТАЙ  
ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

2002 оны Эрүүгийн хууль		2015 оны Эрүүгийн хууль
Бүлэг	Арван есдүгээр бүлэг Өмчлөх өрхийн эсрэг гэмт хэрэг	Арван гуравдугаар бүлэг Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
Зүйл	149 дүгээр зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх  149.1. Өмчлөгч, эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцаж буюу хамгаалж байгаа этгээдэд болон тэдний ойр дотнын хүмүүст хүч хэрэглэх, нэр хүндийг нь гутаасан мэдээ баримт тараах буюу эд хөрөнгийг нь устгахаар заналхийлж эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг шилжүүлэн өгөхийг шаардсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.  149.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, урьд нь хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн их хэмжээний эд хөрөнгө авахаар далайлган сүрдүүлсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.  149.3. Энэ хэргийг урьд нь хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн онц их хэмжээний эд хөрөнгө авахаар далайлган сүрдүүлсэн бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	13.5 дугаар зүйл. Заналхийлэх  Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.  2. Энэ гэмт хэргийг:  2.1. бүлэглэж;  2.2. зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.  3. Энэ гэмт хэргийг:  3.1. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж;  3.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хууль тогтоогч заналхийлж бусдад нөлөөлөх байдлаар Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хэд хэдэн эрх ашигт хохирол, хор уршиг учруулах гэмт хэргийн хэд хэдэн төрлүүд нь объект, объектив талын үндсэн, нэмэгдэл шинжээр ялгагдах боломжтой байдлаар хуульчилсан ба хэрэв объект болон объектив талын шинжүүд ижил төстэй байх тохиолдолд субъект, субъектив талын нэмэгдэл шинжээр ялгагдах боломжтой байдлаар хуульчилж өгсөн.

Заналхийлэх нь бие даасан гэмт хэрэг болон хуульчлагдсанаас гадна зарим төрлийн гэмт хэргийн шинжид туссан. Тухайлбал заналхийлэл, сүрдүүлгийн шинжтэй үйлдэл бүхий хэд хэдэн гэмт хэрэг, заналхийллийг тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал болгон заасан хэд хэдэн гэмт хэрэг тус тус хуульчлагджээ. Энэ нь заналхийлэл, сүрдүүлгийн хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэрэг нийгмийн амьдралд харьцангуй их байсан бөгөөд Эрүүгийн хуулийн зохицуулалт шаардлагатай байсныг харуулж байна. Тухайлбал:

- Хүчиндэх (ЭХ 12.1);
- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (ЭХ 12.2);
- Бэлгийн мөлжлөг (ЭХ 12.3);
- Хүн худалдаалах (ЭХ 13.1);
- Хүн хулгайлах (ЭХ 13.2);
- Хүн барьцаалах (ЭХ 13.3);
- Албадан хөдөлмөрлүүлэх (ЭХ 13.13);
- Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах (ЭХ 14.4);
- Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх (ЭХ 17.6);
- Гэрч, хохирогч, шинжээч, хэлмэрч, орчуулагчид хууль бусаар нөлөөлөх (ЭХ 21.5);
- Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх (ЭХ 21.6);
- Нийтийн албан тушаалтныг заналхийлэх (ЭХ 23.7) гэх мэт.

ХҮСНЭГТ 9. ОЙРОЛЦОО ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭРХЭН ХОЛБОГДОХ ТАЛААРХ ХАРЬЦУУЛАЛТ

№	Гэмт хэрэг	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Заналхийлэх гэмт хэрэгтэй хамааралтай байдал
1	17.6 Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх	Бусдын өмчлөх эрх	Бусдыг эд хөрөнгө, эдийн, эдийн бус хөрөнгийн эрхээ шилжүүлэн өгөхийг шаардсан, заналхийлсэн үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй этгээд байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэг, заналхийлэх гэмт хэргүүд нь объектив талын хувьд ижил төстэй байх боломжтой. Дээрх гэмт хэргүүд гэмт хэргийн бүрэлдэхүүний объектоор ялгагдана.
2	23.7 Нийтийн албан тушаалтныг заналхийлэх	Нийтийн албан тушаалтан, түүний ойр дотнын хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол	Нийтийн албан тушаалтныг тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахгүй байх, үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн; эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэрэг нь заналхийлэх гэмт хэргээс объектив талд тусгагдсан үйлдлээр ижил нөхцөл байдлыг бүрдүүлэх ч объектив талд тусгагдсан халдлагад өртөгчөөр ялгагдана. Мөн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектоор ялгагдана.

№	Гэмт хэрэг	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Заналхийлэх гэмт хэрэгтэй хамааралтай байдал
3	12.1 Хүчиндэх	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, эрүүл мэндийн халдашгүй байдал	Хохирогчтой хүчээр бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 14 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Тус гэмт хэргүүд нь объектив талын хувьд ижил нөхцөл байдлыг бүрдүүлэх ч тухайн үйлдэл хэний эсрэг, ямар зорилгоор, юуны тулд хийсэн эсэхээс хамаарч гэмт хэргийн бүрэлдэхүүний шууд объектоор ялгагдана.
4	12.3 Бэлгийн мөлжлөг	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал	Хохирогчийг бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан идэвхтэй үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	
5	13.1 Хүн худалдаалах	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх	Эрүүгийн хуульд заасан тусгай зорилгоор хүнийг худалдаалахдаа хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх... үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Тус гэмт хэргүүд нь объектив талын хувьд ижил нөхцөл байдлыг бүрдүүлэх ч тухайн үйлдэл хэний эсрэг, ямар зорилгоор, юуны тулд хийсэн эсэх, халдлагад өртөгч болон гэмт хэргийн бүрэлдэхүүний шууд объектоор ялгагдана.



Хүснэгт 9-ийн үргэлжлэл

№	Гэмт хэрэг	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Заналхийлэх гэмт хэрэгтэй хамааралтай байдал
6	13.2 Хүн хулгайлах	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, халдашгүй байдал	Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж... үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	
7	13.3 Хүн барьцаалах	Хүний нийгмийн болон хувийн аюулгүй байдал, халдашгүй, чөлөөтэй байх эрх	Суллах нөхцөл болгон тодорхой үйлдэл хийлгэх, үйлдэл хийхээс түдгэлзүүлэхэд төр, байгууллага, хүнийг албадах зорилгоор болзол тулгаж барьцааны хүнийг алахаар, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж эрхшээлдээ байлгасан үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Тус гэмт хэргүүд нь объектив талын хувьд ижил нөхцөл байдлыг бүрдүүлэх ч тухайн үйлдэл хэний эсрэг, ямар зорилгоор, юуны тулд хийсэн эсэх, халдлагад өртөгч болон гэмт хэргийн бүрэлдэхүүний шууд объектоор ялгагдана.
8	13.13 Албадан хөдөлмөр-лүүлэх	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох	Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж... цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн идэвхтэй үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Тус гэмт хэргүүд нь объектив талын үйлдлийн аргаар ялгарах бөгөөд уг үйлдэл хэний эсрэг, ямар зорилгоор, юуны тулд хийсэн эсэх, халдлагад өртөгч болон гэмт хэргийн бүрэлдэхүүний шууд объектоор ялгагдана.

№	Гэмт хэрэг	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Заналхийлэх гэмт хэрэгтэй хамааралтай байдал
9	14.4 Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүл-хэд саад учруулах	Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, шашны байгуул-лагын хэвийн үйл ажиллагаа	Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлж шашны байгууллагын үйл ажиллагаа, эсхүл шашны зан үйл үйлдэхэд саад учруулсан идэвхтэй үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Тус гэмт хэргүүд нь объектив талын үйлдлийн аргаар ялгарах бөгөөд уг үйлдэл хэний эсрэг, ямар зорилгоор, юуны тулд хийсэн болох, халдлагад өртөгч болон гэмт хэргийн бүрэлдэхүүний шууд объектоор ялгагдана.
10	21.5 Гэрч, хохирогч, шинжээч, хэлмэрч, орчуулагчид хууль бусаар нөлөөлөх	Хэрэг хянан шийдвэрлэх журам, хэрэг хянан шийдвэрлэх хэвийн үйл ажиллагаа, хүний эрх ашиг сонирхол	Гэрч, хохирогчид хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол учруулахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан, шан харамж амласан, өгсөн идэвхтэй үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Тус гэмт хэргүүд нь объектив талын үйлдлийн аргаар ялгарах бөгөөд субъектив талын нэмэгдэл шинж болно. Уг үйлдэл хэний эсрэг, ямар зорилгоор, юуны тулд хийсэн эсэх, халдлагад өртөгч болон гэмт хэргийн бүрэлдэхүүний шууд объектоор ялгагдана.

Хүснэгт 9-ийн үргэлжлэл

№	Гэмт хэрэг	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Заналхийлэх гэмт хэрэгтэй хамааралтай байдал
11	21.6 Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх	Хэрэг хянан шийдвэрлэх журам, хэрэг хянан шийдвэрлэх хэвийн үйл ажиллагаа, хүний амьд явах эрх, эрүүл мэндийн халдашгүй байдал	Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан идэвхтэй үйлдэл	Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.	Гэм буруугийн санаатай хэлбэр	Тус гэмт хэргүүд нь объектив талын үйлдлийн аргаар ижил байх боловч, субъектив талын нэмэгдэл шинж болох уг үйлдэл хэний эсрэг, ямар зорилгоор, юуны тулд хийсэн эсэх, халдлагад өртөгч болон гэмт хэргийн бүрэлдэхүүний шууд объектоор ялгагдана.

Заналхийлэх гэмт хэргийг зүйлчлэхдээ анхаарах асуудлын талаар эрх зүйн сурах бичигт доорх байдлаар тусгажээ.<sup>54</sup> Үүнд:

- Бусдыг эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ шилжүүлэн өгөхийг шаардаж заналхийлсэн бол Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргээр зүйлчилнэ.
- Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах зорилгоор гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга заналхийлсэн бол эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээр зүйлчилнэ.

<sup>54</sup> С.Гантулга, Б.Энхболд дээр дурдсан бүтээл, 2018 он, 86-р тал.

- Нийтийн албан тушаалтныг тодорхой шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахгүй байх, үйл ажиллагаа явуулахгүй байхыг шаардаж заналхийлсэн бол Эрүүгийн хуулийн 23.7 дугаар зүйлд заасан нийтийн албан тушаалтныг заналхийлэх хэргээр зүйлчилнэ.
- Цэргийн албаны үйл ажиллагааг хууль, дүрмийн дагуу явуулсантай нь холбогдуулан дарга, захирагчаа хүч хэрэглэхээр заналхийлсэн бол Эрүүгийн хуулийн 28.2 дугаар зүйлд заасан дарга, захирагчаа эсэргүүцэх гэмт хэргээр зүйлчилнэ.
- Бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардсан байх шинж нь заналхийлэх гэмт хэргийн заавал байх шинж бөгөөд ийм шинжгүй бол энэ гэмт хэрэг болохгүй.
- Заналхийлэх гэмт хэрэг үйлдэх явцдаа хувь хүний нууцыг хууль бусаар олж авсан, задруулсан бол Эрүүгийн хуулийн 13.10 дугаар зүйлд заасан хувь хүний нууцад халдах, Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйлд заасан хувь хүний нууцыг задруулах гэмт хэргээр давхар зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
- Шашин шүтэх, эс шүтэх зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлсэн бол Эрүүгийн хуулийн 14.4 дүгээр зүйлд заасан шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах гэмт хэргээр зүйлчилнэ.

Заналхийлэх гэмт хэргийг эрх зүйн системийн хувьд ижил төстэй ОХУ, БНТУ-д хэрхэн хуульчилсныг харьцууллаа.

## ХҮСНЭГТ 10. ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ЗАРИМ УЛС ОРОНД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ

### ОХУ-ын Эрүүгийн хууль

119 дүгээр зүйл. Алах, хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх гэмт хэрэг

119.1. Бусдыг алахаар эсхүл хүнд гэмтэл учруулахаар заналхийлсэн нь биелэгдэх үндэслэлтэй байсан бол 480 цаг хүртэл хугацаагаар заавал ажил хийх үүрэг хүлээлгэх, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлэх, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

119.2. Улс төр, үзэл бодол, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, аль нэг нийгмийн бүлэгт хамаардгаар нь эсхүл өөрийг нь болон түүний ойр дотнын хүнийг ажил албан тушаал, нийгэмд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай нь холбогдуулан алахаар эсхүл хүнд гэмтэл учруулахаар заналхийлсэн бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаж, эсхүл хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### БНТУ-ын Эрүүгийн хууль

106 дугаар зүйл. Сүрдүүлэх

Өөрт нь эсхүл ойр дотнын хүний амь, хувийн болон бэлгийн эрх чөлөөнд халдахаар сүрдүүлж, мэдэгдсэн бол тухайн этгээдийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Эдийн болон эдийн бус баялагт нь их хэмжээний хохирол учруулж халдахаар сүрдүүлсэн бол хохирогчийн гомдлыг үндэслэн 6 сар хүртэл хорих ялаар шийтгэх эсхүл торгуулийн ял оногдуулна.

2. Сүрдүүлгийг:

- а) Буу;
- б) Тусгай захидал, тэмдэглэгээ;
- в) 2 түүнээс дээш хүмүүс;
- г) Гэмт бүлэглэлийн тусламжтай үйлдсэн бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- д) Сүрдүүлэх зорилгоор санаатайгаар хүн алах, санаатайгаар эрүүл мэндэд хохирол учруулах, эдийн болон эдийн бус баялагт гэм хор учруулсан бол зорилгыг үл харгалзан тухайн гэмт хэргүүдээр ял оногдуулна.<sup>55</sup>

107 дугаар зүйл. “Шантааж”

Эрх болон үүргийн хүрээнд биелүүлбэл зохих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулах эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг шаардах, хууль бус ашиг орлого олох зорилгоор хүч хэрэглэсэн бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах эсхүл торгуулийн ял оногдуулна.

Өөрт болон бусдад ашигтай байдал бий болгох зорилгоор хувь хүний нэр төр, алдар хүндэд хохирол учруулж болохуйц мэдээ, мэдээллийг тараахаар сүрдүүлсэн бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах эсхүл торгуулийн ял оногдуулна.<sup>56</sup>

<sup>55</sup> <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>

<sup>56</sup> <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>

Дүгнэвэл, ОХУ заналхийлэх үйлдлийг тусад нь гэмт хэрэг болгон зүйлчлээгүй бол БНТУ-ын Эрүүгийн хуульд заналхийлэх гэмт хэрэгтэй ижил төсөөтэй агуулга бүхий хоёр зүйл заалт байх бөгөөд уг зүйл, заалтууд тухайн хуулийн 7 дугаар бүлэг буюу Эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг бүлэгт “сүрдүүлэх”, “шантааж” гэх томъёоллоор тусгагджээ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заналхийлэх үйлдлийг бусдыг өөрийн ашиг сонирхолд нийцсэн үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь эсхүл ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хэрэглэхээр заналхийлсэн болон хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулахуйц мэдээ, баримт тараахаар сүрдүүлсэн хэлбэрээр үйлдэгдсэн байх шинжийг хуульчилсан бол ОХУ-ын Эрүүгийн хуульд заналхийлэл нь халдлагад өртөгчийн амь бие эрүүл мэндэд гэм хор учруулахаар сүрдүүлж, мөн тухайн хүний нийгмийн гарал үүсэл, үзэл суртал, шашин шүтлэг, ажил хөдөлмөрт нь холбогдуулан алахаар заналхийлэх үйлдлийг тооцсон байна.

БНТУ-ын Эрүүгийн хуульд заналхийлэл нь сүрдүүлэх хэлбэрээр буюу “өөрт нь эсхүл ойр дотнын хүнд хүч хэрэглэхийг мэдэгдэх”, шантаажлах буюу “тодорхой үйл ажиллагаа явуулах эсхүл явуулахгүй байхыг шаардаж хүч хэрэглэх” байдлаар үйлдэгдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг ажээ.

Дээрх орны хуулиудад заналхийлэх гэмт хэргийн төрлүүд нь үйлдэл, үйлдэгдэх байдал, үйлдлийн улмаас хүрэх эцсийн зорилго зэргээр ялгагдаж байгаа ч халдлагад өртөгч, халдлагын хэлбэрээр ижил нөхцөл байдлыг агуулж байна.

## 2.2. Заналхийлэх гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхүүд 2018-2020 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.5 дугаар зүйл “Заналхийлэх” гэмт хэргээр нийт 31 хэргийг шийдвэрлэжээ.<sup>57</sup> Эдгээр шийдвэрийн 5 нь давж заалдах шатны шүүх, 1 нь хяналтын шатны шүүхээр хянагдсан байна.

---

<sup>57</sup> Монгол Улсын шүүхийн цахим сан <http://new.shuukh.mn/eruanhan>

ХҮСНЭГТ 11. АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР 2018-2020 ОНД  
ХЯНАН ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ<sup>58</sup>

Гэмт хэрэг	Гэмт хэргийн тоо			Оногдуулсан ялын төрөл			
	2018 он	2019 он	2020 он	Торгох	Нийтэд тустай ажил хийлгэх	Хорих ял	Хэргийг прокурорт буцаасан
Заналхийлэх	6	13	12	14	7	6	2

ЭХТА-ийн 13.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 31 хэргээс прокурорт буцаасан 2 тохиолдол байна. Шүүхээс 1 шүүгдэгчид хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн ба бусад шүүгдэгчид доорх ялыг оногдуулжээ. Үүнд:

- торгох – 15;
- нийтэд тустай ажил хийлгэх – 7;
- 6 сараас 2 жил хүртэл хорих – 6.

Заналхийлэх гэмт хэрэг нь ЭХ-ийн Ерөнхий ангийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хөнгөн гэмт хэргийн ангилалд багтах бөгөөд ЭХ-ийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл хэсэгт заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болдог.

Шүүх 1 шүүгдэгчийг хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн боловч ЭХ-ийн 7.2 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээний аль нэг төрлийг хэрэглээгүй байна. Эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх зорилготой. ЭХ-ийн 7.2 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээ нь энэхүү зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнссэн тохиолдолд хэрэглэх боломжтой байхаар хуульчилсан.

Шүүх уг зүйлийг хэрэглэн ял оногдуулахгүйгээр тэнссэн тохиолдолд гэмт хэргийн хор уршгийг арилгуулах, зан үйлээ засах, тодорхой ажил үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа

<sup>58</sup> Монгол Улсын шүүхийн цахим сан <http://new.shuukh.mn/eruanhan>

хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэхийг шүүгдэгчид даалгах боломжтой. Мөн тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох албадлагын арга хэмжээг авч болно. Гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүй тэнссэн тохиолдолд үүрэг хүлээлгэх, хязгаарлалт тогтоох арга хэмжээний төрлүүдээс хэрэглэж байх нь нэг талаас дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас хохирогчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Судалсан шүүхийн шийдвэрүүдийн дийлэнх хувьд заналхийлэхдээ зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэх, согтуурсан үедээ заналхийлэх, хохирогчийн эрхшээлдээ байгаа, гэр бүлийн хамааралтай байдлыг далимдуулан заналхийлэх тохиолдол эзэлж байна. Иймд хорих ял оногдуулах буюу оногдуулахгүйгээр тэнссэн аль ч тохиолдолд зан үйлээ засах сургалтад хамрагдахыг үүрэг болгох, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах гэх мэт албадлагын арга хэмжээний төрлүүдээс аль тохирохыг сонгож хэрэглэж хэвших шаардлагатай гэж үзлээ.

■ Заналхийлэх гэмт хэргийг бусад гэмт хэрэгтэй давхар зүйлчилсэн байдал

Улсын Дээд шүүх 2019 оны 553 дугаар тогтоолдоо “заналхийлэхдээ бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардаж сүрдүүлсэн үйлдэл холбогдлыг хэрэгжүүлсэн эсэхээс үл хамаарч заналхийлэх гэмт хэргийн шинж хангагдсанд тооцогдох бөгөөд хэрэв уг үйлдлээ хийсэн нь тусдаа гэмт хэргийн шинжийг хангасан тохиолдолд Эрүүгийн хуульд заасан тохирох зүйл, хэсгээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх учиртай” хэмээн тайлбарлажээ.

1. ЭХ-ийн 13.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар:

- Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулж заналхийлсэн - 2;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж заналхийлсэн - 1;
- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангаж, заналхийлсэн - 1;
- Заналхийлэх байдлаар бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орсон - 1;



- Заналхийлэх байдлаар хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах - 1 зэрэг үйлдлийг давхар зүйлчлэн, ял шийтгэл оногдуулсан байна.
2. ЭХ-ийн 13.5 дугаар зүйлийн 13.5.2.1 дэх хэсэгт зааснаар давхар зүйлчилсэн 2 тохиолдол байна. Үүнд:
- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2.1) гэмт хэрэг үйлдэхдээ заналхийлэх үйлдлийг бүлэглэж хийсэн - 1;
  - Хулгайлах (17.1) гэмт хэрэг үйлдэхдээ заналхийлэх үйлдлийг бүлэглэж хийсэн - 1 тохиолдол бүртгэгджээ.
3. ЭХТА-ийн 13.5 дугаар зүйлийн 13.5.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт давхар зүйлчлэн анхан шатны шүүхээс ял оногдуулсан тохиолдлыг авч үзвэл:
- Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулж, бага насны хүүхдийг хүчирхийлж улмаар зэвсэг, зэвсгийн чанартай зүйл ашиглаж заналхийлсэн - 1;
  - Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулж улмаар зэвсэг, зэвсгийн чанартай зүйл ашиглаж заналхийлэн бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орсон - 1;
  - Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулж, 14-өөс дээш 18 насанд хүрээгүй хүнийг хүчирхийлж улмаар зэвсэг, зэвсгийн чанартай зүйл ашиглаж заналхийлсэн -1;
  - Зэвсэг, зэвсгийн чанартай зүйл ашиглан заналхийлэх байдлаар бусдын орон байранд нэвтрэн орсон - 1;
  - Галт зэвсэг ашиглан заналхийлсэн - 2 үйлдэл тус тус бүртгэгдэж, холбогдох зохицуулалтын дагуу давхар зүйлчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ.

### 2.3. Бүлгийн дүгнэлт

2002 оны Эрүүгийн хуульд заналхийлэх нь зарим төрлийн гэмт хэргийн шинж болж байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд бие даасан гэмт хэрэг болгон хуульчилжээ. Ингэснээр хувь хүн, албан тушаалтны хооронд заналхийлэх, сүрдүүлэх үйлдлээр хүний хувийн эрх, эрх чөлөөг зөрчих, албаны чиг үүрэг, бүрэн эрхээ урвуулан ашиглах, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлөх байдлаар илрэн гарч байсан гэмт хэргүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, энэ төрлийн гэмт хэрэг дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн байна. Хууль тогтоогч заналхийлэхийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилснаас гадна зарим төрлийн гэмт хэргийн үндсэн шинж, тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилсан.

Анхан шатны шүүхүүд 2018-2020 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.5 дугаар зүйл “Заналхийлэх”-ээр нийт 31 хэргийг шийдвэрлэснээс үзвэл Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйл хууль хэрэглээнд орсон байна гэж дүгнэлээ. УДШ-ээс тодорхой гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ заналхийлэх гэмт хэргийн шинж хэзээ хангагдсан гэж үзэх болон Эрүүгийн хуулийн бусад зүйл хэсгээр давхар зүйлчлэхтэй холбоотой тайлбар хийснийг шүүхийн практикт хэрэглэж байна.

Заналхийлэх гэмт хэрэгт 4 төрлийн санкц байгаа боловч зорчих эрхийг хязгаарлах ял нь хэрэгжиж эхлээгүй байгаагаас үүдэн тухайн зүйл, ангид заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ихэвчлэн торгох ял оногдуулж байгаа нь бусдыг заналхийлж хүчирхийлсэн, бусдын эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулж заналхийлсэн, бусдын орон байранд заналхийлж нэвтэрсэн зэрэг тухайн заналхийллийн гэмт хэргийн онцлог нөхцөлд тохирсон хариуцлагын хэлбэр байж чадахгүй байна.

Нөгөө талаас, Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан эрүүгийн хариуцлагын зорилго болох “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг” хангахгүй байна. Тухайлбал, заналхийлэх гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс ял оногдуулахгүй тэнссэн тохиолдолд үүрэг хүлээлгэх, хязгаарлалт тогтоох албадлагын арга хэмжээний төрлүүдээс хэрэглэсэн тохиолдол байхгүй байна. Уг арга хэмжээний төрлүүдээс хэрэглэж байх нь нэг талаас дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нөгөө талаас хохирогчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

## Гурав. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйл)

### 3.1. Эрүүгийн хуулийн зохицуулалт

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой”<sup>59</sup> хэмээн тунхагласан. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон пактад “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчлах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчлахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой”<sup>60</sup> хэмээн заасан. Түүнчлэн Монгол Улс Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц зэрэг олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орсон билээ.

Манай улс Үндсэн хуулиараа иргэдийнхээ үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсны нэг нь ялгаварлан гадуурхахаас ангид байх<sup>61</sup> эрх юм. Ийнхүү олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, Үндсэн хуулиараа баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд

<sup>59</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946 оны 12 дугаар сарын 10. 1, 2 дугаар зүйл

<sup>60</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт (Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1968 оны 1 дүгээр сарын 5-нд гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-нд соёрхон баталсан), 26 дугаар зүйл

<sup>61</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

нөхөн сэргээх хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд Эрүүгийн хуулийн гүйцэтгэх үүрэг онцгой ач холбогдолтой.

2002 оны Эрүүгийн хуульд ялгаварлан гадуурхахтай холбоотой тодорхой төрлийн гэмт хэргүүдийг Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт хамааруулж байсан бөгөөд үүнд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих, иргэдийн үзэл бодлоор нь мөрдөн мөшгөх, шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхаж, мөрдөж мөшгөсөн үйлдлүүд хамаарч байсан. Өөрөөр хэлбэл, иргэнийг зөвхөн тодорхой эрхээ хэрэгжүүлснийх нь төлөө ялгаварлан гадуурхсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож байсан.

Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт хүнийг ялгаварлан гадуурхаж, хувийн эрх, эрх чөлөөг нь хязгаарласан үйлдлийг бүхэлд нь “Ялгаварлан гадуурхах” гэмт хэрэгт тооцсон.<sup>62</sup>

#### 14.1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ<sup>63</sup>

1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан).
2. Энэ гэмт хэргийг:
  - 2.1. бүлэглэж;
  - 2.2. хүч хэрэглэж;
  - 2.3. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>62</sup> ХЗДХЯ. Монгол Улсын хууль, Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга). Сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ., 2017 он. 134 дэх тал

<sup>63</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015 он

Эрүүгийн хуульд заасан ялгаварлан гадуурхах гэмт хэрэг нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан буюу хүний дээрх хувийн эрх, эрх чөлөөнд халдсан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй юм. Ялгаварлан гадуурхах нь хөнгөн хэргийн ангилалд багтдаг, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болно.

ХҮСНЭГТ 12. “ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ” ГЭМТ ХЭРГИЙГ ӨМНӨ МӨРДӨГДӨЖ БАЙСАН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ИЖИЛ ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

	2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
Бүлэг	Арван наймдугаар бүлэг Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	Арван дөрөв дүгээр бүлэг Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
Зүйл	132 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих  132.1. Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэнийг ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарласны улмаас гэм хор учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	14.1 дүгээр зүйл. Ялгаварлан гадуурхах  1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
<p>134 дүгээр зүйл. Иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгөх</p> <p>134.1. Иргэнийг улс төрийн нам, төрийн бус байгууллагад сайн дураараа эвлэлдэн нэгдсэний төлөө ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарласан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, хоёр зуун тавиас гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>2. Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1. бүлэглэж;</p> <p>2.2. хүч хэрэглэж;</p> <p>2.3. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
<p>143 дугаар зүйл. Шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх</p> <p>143.1. Хүнийг шүтэж байгаа шашнаар нь ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх, хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, бусад хэлбэрээр эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгжээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p>	

- Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж

**Объект:** Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх. Хохирогч нь ялгаварлан гадуурхагдсаны улмаас эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн байна.

*Объектив тал:* Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байна. Ялгаварлан гадуурхсан дээрх үйлдлийн аль нэгийг хийж, эрх, эрх чөлөөг хязгаарласан үеэс төгсдөг, хор уршиг учирсан байхыг шаарддаггүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм.

*Субъект:* Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.

*Субъектив тал:* Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Хүнийг ялгаварлан гадуурхах нь хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байх ба хувийн таарамжгүй харилцаа, өс хонзонгийн сэдэлтээр үйлдэгдэх боломжтой бөгөөд сэдэлт зүйлчлэлд нөлөөлөхгүй.

*Хүндрүүлэх шинж:* Энэ гэмт хэргийг бүлэглэж, хүч хэрэглэж, албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэх шинжид хамаарахаар заасан.

Эрүүгийн эрх зүйн сурах бичигт хуулийн нэр томъёог доорх байдлаар тайлбарлажээ.<sup>64</sup> Үүнд:

*Бэлгийн чиг баримжаа* гэж аль нэг хүйсээс өөрийнхөө хайр дурлал болоод бэлгийн харилцаанд орох болон татагдах хүний үндсэн шинж чанарын нэг бөгөөд хүн үүнийг хэн нэгэн болон ямар нэг зүйлийн оролцоотой эсвэл хүчээр хүсдэггүй, харин байгалиас заяаснаар өөрийн мэдэлгүй мэдэрдэг мэдрэмж. Иймээс энэ байдлаар нь ялгаварлан гадуурхах нь жам ёсны эрхийн зөрчилд тооцогдоно. Бэлгийн чиг баримжааг дотор нь гетеросекс, гомосекс, бисекс, асекс гэх үндсэн 4 төрөлд хуваадаг. Гетеросекс гэдэг нь өөрөөсөө эсрэг хүйсийн хүнд татагддаг хүн, гомосекс гэдэг нь өөртэйгөө ижил хүйсийн хүнд татагддаг хүн, бисекс гэдэг нь аль аль хүйсийн хүнд татагддаг, асекс бэлгийн дур хүслийг мэдэрдэггүй буюу бэлгийн чиг баримжаагүй хүн юм.

*Хүйсийн чиг баримжаа* гэж охин эсвэл хүү, эмэгтэй эсвэл эрэгтэй гэдгээ мэдрэх хүний дотоод мэдрэхүй юм.

<sup>64</sup> С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүйн тусгай анги сурах бичиг, УБ., 2018 он

*Эрүүл мэндийн нөхцөл байдал* гэж хүн өвчин, эмгэгийн улмаас бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд эрүүл хүнтэй харьцуулахад доогуур түвшинд байхыг хэлнэ.

*Эрх чөлөөг нь хязгаарласан* гэж иргэний төрөлхийн болон жам ёсны, түүнчлэн бусад эрхийг нь хориглох буюу хязгаарлахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, сурч боловсрох, улс төрийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг нь зөрчих, хязгаарлахыг<sup>65</sup> ойлгоно.

*Бүлэглэж* гэдэг нь энэ гэмт хэргийг 2 ба түүнээс олон хүн санаатай нэгдэж хамтран үйлдсэн байхыг хэлнэ.

*Хүч хэрэглэсэн* гэдэг нь хохирогчийн амь бие, эрүүл мэндэд халдах, гэмтэл, хохирол учруулах зэрэг шинжээр илэрнэ.

*Албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн* гэдэгт албан тушаалтан өөртөө эсхүл өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгуулах зорилгоор өөрөө эсхүл өөрийн удирдлагад ажилладаг албан тушаалтнаар дамжуулан албаны эрх нөлөөг урвуулан ашиглах үйлдлийг ойлгоно.<sup>66</sup>

- Ялгаварлан гадуурхахтай холбоотой Эрүүгийн хуулийн тусгай зүйл, заалтууд

Бусдыг үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж гэмт хэрэг үйлдсэн бол зарим гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл болгон зүйлчилсэн байна. Үүнд:

- Хүнийг үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алах (ЭХ-ийн 10.1 дүгээр зүйлийн 10.1.2.14);
- Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (ЭХ 11.4);
- Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах (ЭХ 11.6);
- Эрүү шүүлт тулгах (ЭХ.21.12);
- Үндэсний эв нэгдлийг бусниулах (ЭХ 19.9 дүгээр зүйл).

<sup>65</sup> С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүйн тусгай анги сурах бичиг, УБ., 2018 он, 113 дахь тал

<sup>66</sup> С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүйн тусгай анги, Сурах бичиг, УБ, 2018 он, 114 дэх тал



ХҮСНЭГТ 13. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН БУСАД БҮЛЭГ, ЗҮЙЛД ЗААСАН “ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЖ”  
ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	ЭХ тусгай ангийн бүлэг	ЭХ-ийн тусгай ангийн зүйл, заалт	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Ялгаварлан гадуурхах гэмт хэргээс ялгагдах онцлог
1	Аравдугаар бүлэг Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10.1 дүгээр зүйл. Хүнийг санаатай алах	Хүний амьд явах эрх	Хүнийг алсан идэвхтэй үйлдэл	14 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай хувь хүн	Гэм буруугийн санаатай хэлбэр	Хүнийг үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол энэ гэмт хэргийн хүндрүүлэх шинж болно.
2	Арван нэгдүгээр бүлэг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт	11.1, 11.4, 11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдал	Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан идэвхтэй үйлдэл	14, 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай хувь хүн	Гэм буруугийн санаатай хэлбэр	Хүнийг үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол энэ гэмт хэргийн хүндрүүлэх шинж болно.

Хүснэгт 13-ын үргэлжлэл

№	ЭХ тусгай ангийн бүлэг	ЭХ-ийн тусгай ангийн зүйл, заалт	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Ялгаварлан гадуурхах гэмт хэргээс ялгагдах онцлог
3	Арван есдүгээр бүлэг Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19.9 дүгээр зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах	Үндэсний эв нэгдэл, үндэстэн, ястны тэгш эрх	Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байна.	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн	Гэм буруугийн санаатай хэлбэрээр, хүмүүсийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, шашны үзэл номлолоор дайсагнуулах, тусгай зорилго эвдрэлцүүлэх гэсэн тусгай зорилгоор үйлдэгдэнэ.	Хүмүүсийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, шашны үзэл номлолоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх гэсэн тусгай зорилго байхгүй бол энэ гэмт хэргийн шинж үгүйсгэгдэнэ.
4	Хорин нэгдүгээр бүлэг Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	Хэрэг хянан шийдвэрлэх журам, хүний халдашгүй байх эрх	Бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон идэвхтэй үйлдэл	Бусдад эрүү шүүлт тулгасан төрийн албан хаагч байна.	Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Энэ гэмт хэргийг бусдаас тайлбар мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял шийтгэл оногдуулах, ялгаварлан гадуурхах зорилгоор үйлдсэн бол Эрүү шүүлт тулгах гэмт хэргээр зүйлчлэгдэнэ.	Бусдаас тайлбар мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял шийтгэл оногдуулах, ялгаварлан гадуурхах зорилгоор үйлдсэн бол Эрүү шүүлт тулгах гэмт хэргээр зүйлчлэгдэнэ.

Хүснэгт 13-ын үргэлжлэл

№	ЭХ тусгай ангийн бүлэг	ЭХ-ийн тусгай ангийн зүйл, заалт	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Ялгаварлан гадуурхах гэмт хэргээс ялгагдах онцлог
5	Хорин есдүгээр бүлэг. Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	29.5 дугаар зүйл. Төрлөөр устгах	Давхар объекттой. Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайван шууд, хүний амьд явах эрх, эрүүл мэндийн халдашгүй байдал нэмэгдэл шууд объект	Үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор хүнийг алсан, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан, эсхүл төрөлтийг хүчээр зогсоосон, эсхүл хүүхдийг бусад бүлэгт шилжүүлсэн, албадан зайлуулсан, эсхүл амьдралын өөр нөхцөл бий болгох замаар тэднийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн устаж үгүй болоход хүргэсэн, эсхүл хүчээр сураггүй алга болгосон идэвхтэй үйлдэл	16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн	Гэм буруугийн санаатай хэлбэр. Энэ гэмт хэргийг үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор үйлдсэн байна.	Энэ гэмт хэргийг үндэс, угсаа, арьсны өнгө, шашны тодорхой бүлгийг устгах зорилгоор үйлдсэн байна.

Хүнийг ялгаварлан гадуурхаж амь бие, эрүүл мэндэд халдсан үйлдэл, эс үйлдэхүйг тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл болгон заасан нь Үндсэн хуулиар баталгаажуулсан ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалахад чухал үр нөлөөтэй юм.

## 3.2. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийг шийдвэрлэж буй байдал

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг нь цагдаагийн байгууллагын албан ёсны статистик мэдээний маягад 14.11 дүгээр зүйлээрээ тусгагдаагүй байна. Цагдаагийн Ерөнхий газраас сар тутам гаргадаг “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ”-д Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 2017 онд 29<sup>67</sup>, 2018 онд 8, 2019 онд 3<sup>68</sup> бүртгэгджээ. Гэвч уг мэдээнд зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлгийн нэрийг л тусгасан учир эдгээр хэргийн дотор “Ялгаварлан гадуурхах” гэмт хэрэг бүртгэгдсэн эсэх нь тодорхойгүй юм.

Монгол Улсын шүүхийн 2018 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны тайлангийн<sup>69</sup> “Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг” гэсэн 2.2 дахь хүснэгтэд энэ гэмт хэргийн тухай нарийн мэдээлэл байхгүй, 2017 онд 2382, 2018 онд 2353 хэргийг “бусад гэмт хэрэг” хэмээн бөөн дүнгээр тусгажээ. Харин Монгол Улсын шүүхийн 2019 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлангийн<sup>70</sup> “Хянан шийдвэрлэсэн зарим хэргийн харьцуулалт” гэсэн 2.2 дахь хүснэгтэд Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг) гэсэн багана оруулсан байх боловч хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн тоон мэдээлэл тусгагдаагүй байна.

ЦЕГ-ын Статистик мэдээллийн хэлтсээс авсан судалгаагаар 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 2 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан 4 хэрэг бүртгэгдсэнээс<sup>71</sup> 2018 онд 2, 2019 онд 1, 2020 онд 1 хэрэг тус тус бүртгэгджээ. Хэргийг ангилж үзвэл үндэс угсаа, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан

<sup>67</sup> <https://police.gov.mn/a/4189>

<sup>68</sup> <https://police.gov.mn/a/4867>

<sup>69</sup> Монгол Улсын шүүхийн 2018 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны тайлан, 13-14 дэх тал <http://www.judoinstitute.mn/main/236--2018-.html>.

<sup>70</sup> Монгол Улсын шүүхийн 2019 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлан, 8-9 дэх тал <http://www.judoinstitute.mn/main/244--2019-3-html>

<sup>71</sup> ЦЕГ-ын МДШШУА-ны Статистик мэдээллийн хэлтсийн мэдээлэл, 2020 он

гадуурхсан 3, бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхсан 1 тохиолдол байна.

Цагдаагийн байгууллага “гэмт хэргийн шинжгүй” гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгох саналтайгаар 2, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар 1 хэргийг прокурорын байгууллагад шилжүүлжээ. 2020 онд шүүхээр шийдэгдсэн “ялгаварлан гадуурхах” хэргийн тухайд Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2020 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 2020/ШЦТ/868 дугаартай шийтгэх тогтоол гарчээ.<sup>72</sup>

## ТОХИОЛДОЛ 2.

Шүүх Нийслэлийн Прокурорын газраас шүүгдэгч Г-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргээс Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг... хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.<sup>73</sup> Шүүх энэхүү шийдвэрийнхээ үндэслэлийг дараах байдлаар тайлбарласан байна.

...шүүх хэрэгт авагдаж, шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан баримтууд болон шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн талуудын мэтгэлцээнийг шинжлэн судлаад шүүгдэгч Г-ийн 2019 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр өөрийн фейсбүүк хаягаас олон нийтийн цахим хуудсанд “...Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд муугаар нөлөөлж халдварт өвчин тараахаас өгсүүлээд, бусдыг садар самуунд уруу татаж, хөвгүүд залуусыг гаж буруу чиг хандлагатай болгох зэрэг их хор хөнөөлтэй хүмүүс учир бид цаашдаа муу сайн нийгмийн хог шааруудыг хэлж байгаад янзлаад өгнө, илчилж ил гаргана...” гэх мэдээллийг байршуулж Д-г хүйс, үзэл бодол, бэлгийн хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар нь ялгаварлан гадуурхаж, эрх, эрх чөлөөг хязгаарласан гэх үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн шинжийг хангаагүй байна гэж дүгнэж, шүүгдэгч Г-г энэ гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцох хууль зүйн үндэслэлгүй байх тул түүнд холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Ялгаварлан гадуурхах” гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ. Учир нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн тодорхойлох хэсэгт заасан “... эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол...” гэх объектив шинж тогтоогдохгүй, хохирогч Д-г ялгаварлан гадуурхсанаар хохирогчийн эрх, эрх чөлөөг хэрхэн хязгаарласан үйл баримт хэрэгт авагдаагүй байх тул шүүгдэгч Г-г Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй байна...” гэж дүгнэсэн байна.

<sup>72</sup> file:///C:/Users/User/Downloads/106\_2020\_0818\_%D0%AD\_2020-10-06\_868.pdf

<sup>73</sup> 2020 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 2020/ШЦТ/868 дугаартай Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын хэсгээс

Уг шийтгэх тогтоолд хохирогчийн эрх, эрх чөлөөг нь хязгаарласан буюу төрөлхийн болон жам ёсны, түүнчлэн бусад эрхийг нь хориглосон, хязгаарласан шинж байхгүй тул ялгаварлан гадуурхах гэмт хэргийн шинжийг хангахгүй байна гэж дүгнэн хэрэгсэхгүй болгожээ. Эндээс хэдийгээр холбогдогчийн зүгээс хохирогчийг ялгаварлан гадуурхсан үйлдэл нь тогтоогдсон ч хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан шинжгүй л бол гэмт хэрэгт тооцох боломжгүй байгаа Эрүүгийн хуулийн зохицуулалт хэргийн шийдвэрлэлтийн байдалд сөргөөр нөлөөлж, хохирогч хохирсон хэвээр үлдэхэд хүргэжээ.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцдаа Монгол Улсын шүүхийн цахим сангаас ялгаварлан гадуурхах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг хайхад уг цахим санд хэд хэдэн удаа буруу мэдээлэл оруулсан байгаа нь ажиглагдлаа. Жишээ нь, 2019 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 1015 дугаартай шийтгэх тогтоолыг байршуулахдаа Эрүүгийн хуулийн зүйлийг 14.1.1 Ялгаварлан гадуурхах гэж бичсэн боловч Тогтоох хэсгийн 1-д “шүүгдэгч Гал овогт Б.Х-г хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай. Харин Тогтоох хэсгийн 2 дахь хэсэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 1-д зааснаар шүүгдэгч Б.Х-г 1000 (мянган) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 1,000,000 (нэг сая) төгрөгөөр торгох ялаар шийтгэсүгэй” гэх мэт энэхүү шийтгэх тогтоолын талаар зөрүүтэй мэдээлэл оруулсан байлаа. Шүүхийн шийтгэх тогтоолыг бүрэн эхээр нь татаж уншихад хүний биед хүндэвтэр хохирол учруулсан гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байх боловч Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 1-д зааснаар зүйлчилжээ.<sup>74</sup> Мөн 2018 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 937 дугаартай тогтоолын<sup>75</sup> талаарх мэдээллийг шүүхийн цахим санд байршуулахдаа дээрх байдлаар алдаа гаргасан байсныг дурдах нь зүйтэй гэж үзлээ.

<sup>74</sup> <http://new.shuukh.mn/eruuhan/37875/view>

<sup>75</sup> <http://new.shuukh.mn/eruuhan/26554/view>

### 3.3. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийг зарим улс оронд хуульчилсан байдал

Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгааны<sup>76</sup> “Олон улсын болон бусад улсын хууль, эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал” гэсэн бүлэгт эрүүгийн хуулийн зохицуулалттай холбоотой дараах мэдээллийг тусгажээ. Үүнд:

Колумбын Бүгд Найрамдах улсын Эрүүгийн кодын 134В дүгээр зүйлд “... алагчлах үзлийг”:

1. Олон нийтийн газар, олон нийтэд зориулсан мөн олон нийтэд нээлттэй газарт;
2. Олон нийтийн хэвлэлд;
3. Төрийн албан хаагч үйлдсэн;
4. Уг үйлдэл нь хүүхэд, охид, өсвөр, дунд эргэм насныхан эсхүл насанд хүрсэн этгээдийн эсрэг чиглэсэн бол...” оногдуулах шийтгэлийг нэмэгдүүлэхээр хуульчилсан байна.<sup>77</sup>

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлд Ялгаварлан гадуурхсан, өөрөөр хэлбэл албан тушаалын байдлаа ашиглаж хүнийг хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, хэл, нийгмийн гарал, эд хөрөнгө ба албан тушаалын байдал, оршин суугаа газар, шашин шүтлэг, итгэл үнэмшил, аль нэг олон нийтийн байгууллага, нийгмийн бүлэгт хамаардаг байдлаар нь хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн бол эрүүгийн хариуцлага оногдуулахаар заажээ. Мөн хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэргүүдийг үйлдэхдээ ялгаварлан гадуурхсан бол хүндрүүлэх шинж гэж хуульчилжээ.<sup>78</sup> Харин ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 5.62 дугаар зүйлд Ялгаварлан гадуурхсан, өөрөөр хэлбэл хүнийг ба иргэнийг хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, хэл, нийгмийн гарал, эд хөрөнгө, гэр бүл, нийгмийн ба ба албан тушаалын байдал, оршин суугаа газар, шашин шүтлэг, итгэл үнэмшил, аль нэг олон нийтийн байгууллага, нийгмийн бүлэгт хамаардаг, эсхүл хамаардаггүй байдлаар нь

<sup>76</sup> Хууль зүй дотоод хэргийн яамны захиалгаар Хууль зүйн Үндэсний Хүрээлэнгээс хийсэн.

<sup>77</sup> Хууль зүйн Үндэсний Хүрээлэн. Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа. Хууль зүйн судалгааны төв, УБ., 2019 он, 26 дахь тал. <http://nli.gov.mn/wp-content/uploads/2019/07/yalgawarlan-gaduurhah.pdf>

<sup>78</sup> <http://stykrf.ru/111>

эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн бол иргэн, хуулийн этгээдэд торгуулийн арга хэмжээ авахаар заажээ.<sup>79</sup>

Турк Улсын Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйлд Үзэн ядалт, ялгаварлан гадуурхах гэмт хэргийг хуульчилжээ. Уг хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт Хэл, үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хөгжлийн бэрхшээл, улс төрийн үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэгээс нь хамааран үзэн ядаж:

- a. Тухайн этгээдийн өмчлөлийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах, түрээслэх, хөлслөхөд;
- b. Тухайн этгээдэд олгох төрийн үйлчилгээ авахад;
- c. Тухайн этгээд шинэ ажилд ороход;
- d. Тухайн этгээд бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь саад учруулсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх<sup>80</sup> тухай зохицуулсан ажээ.

Дээрх улсуудын Эрүүгийн хуулийн зохицуулалтаас харахад ялгаварлан гадуурхсан бүх үйлдэл, эс үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулах бус харин гэмт хэргийн субъект, объектив шинжээр нь бусад зөрчлөөс ялгаж хуульчилсан байна.

### 3.4. Бүлгийн дүгнэлт

Монгол Улс ялгаварлан гадуурхах буюу хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан үйлдлийг Эрүүгийн хуулиар хамгаалсан нь Үндсэн хуулийн заалтыг амьдралд хэрэгжүүлэх, манай улс нэгдэн орж, соёрхон баталсан Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилттой нийцэж байна.

Хүнийг ялгаварлан гадуурхах үзэгдэл нийгэмд газар авсан ч хуулиар шийдэгдэх явдал хангалтгүй байна. Эрүүгийн хуульд зохицуулагдаагүй үлдсэн болон засан сайжруулах шаардлагатай зарим асуудал байх тул,

<sup>79</sup> [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_34661/8b36cedfef8c1b205cdbdcd85ee7a7dc250f5109/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/8b36cedfef8c1b205cdbdcd85ee7a7dc250f5109/)

<sup>80</sup> <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>



ялгаварлан гадуурхахтай тэмцэх эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэх боломжгүй байна.<sup>81</sup>

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй 30 гаруй хуулиар ялгаварлан гадуурхалтыг хориглосон боловч түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулжээ. Иймд бусад хуулийг зөрчиж хүнийг ялгаварлан гадуурхсан үйлдэл бүрт тохирох хариуцлагын төрөл, хэмжээг хуульчлах нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх заалтыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх болно.

Шүүхийн практик болон цагдаагийн байгууллагад шалгагдсан гэмт хэргийн хувьд хэдийгээр холбогдогчийн зүгээс хохирогчийг ялгаварлан гадуурхсан үйлдэл нь тогтоогдсон ч хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан шинжгүй л бол гэмт хэрэгт тооцох боломжгүй байна. Хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан байх нь Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлд заасан “ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн объектив талын заавал байх шинж учраас энэ шинжийг хангаагүй тохиолдолд хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэрэг үүссэн ч шүүхийн шатанд хэрэгсэхгүй болох гол шалтгаан болж байна.

Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн талаарх тоон мэдээлэл хомс байна. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг болон шүүхээр шийдвэрлэсэн хэргийн албан ёсны мэдээнд ЭХ-ийн 14.1 дүгээр зүйл буюу “Ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн талаарх мэдээлэл огт байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг судлах, уг зүйлийг хэрэглээнд оруулах, хариуцлагын үр нөлөөг үнэлэхэд учир дутагдалтай байна.

---

<sup>81</sup> Хууль зүйн Үндэсний Хүрээлэн. Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа, Хууль зүйн судалгааны төв, УБ., 2019 он, 26 дахь тал <http://nli.gov.mn/wpcontent/uploads/2019/07/yalgawarlan-gaduurhah.pdf>

## Дөрөв. ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГӨХ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ (Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйл)

Монгол Улс Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт "...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэж заасан.<sup>82</sup>

2002 оны Эрүүгийн хуульд иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгөх (134 дүгээр зүйл), жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зөрчих (132 дугаар зүйл), шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх (143 дугаар зүйл) гэсэн зүйлүүд байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд дээрх зүйлүүдийг нэгтгэн мөрдөж мөшгөх гэмт хэргийг бие даасан зүйл болгон хуульчилсан байна.

### 4.1. Эрүүгийн хуулийн зохицуулалт

#### 13.12 ДУГААР ЗҮЙЛ. ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГӨХ

1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан).
2. Эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгөсөн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Нэр томьёоны тайлбар:

*Мөрдөн мөшгөх* гэж Үзэл бодлоо илэрхийлсэн, шашин шүтэх, эс шүтэх, нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдсэн болон бусад үйлдлийнх нь төлөө хуульд заасан үндэслэл, журмаас гадуур мөрдөн мөшгөсөн аливаа

<sup>82</sup> Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, 2 дугаар бүлэг

үйлдлийг ойлгоно.<sup>83</sup>

*Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд* гэж Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.1, 6.1.2 дугаар зүйлд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий этгээдээс бусад этгээдийг ойлгоно.

*Мөрдөн шалгах эрхтэй эрх бүхий албан тушаалтан* гэж Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.1, 6.1.2 дугаар зүйлд зааснаар Тагнуулын байгууллага, Авлигатай тэмцэх байгууллага, Цагдаагийн байгууллага байна.<sup>84</sup>

*Хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан* гэж ЭХХШТХ-д заасан эрх бүхий албан тушаалтан ЭХХШТХ, ЗШШТХ, ГАТХ зөрчиж мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулсан байхыг ойлгоно.

Эрүүгийн эрх зүйн хувьд хууль бусаар мөрдөж мөшгөх нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэгт багтах бөгөөд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, хөнгөн хэрэг гэмт хэрэг байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний 4 талт онолоор Хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргийг авч үзвэл:

**Объект:** Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх

**Объектив тал:** Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн идэвхтэй үйлдэл байна. Дээрх үйлдэл хийгдсэн даруйд төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

**Субъект:** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй хүн байна (мөрдөн шалгах эрхтэй эрх бүхий албан тушаалтан).

**Субъектив тал:** Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдэл буюу бусдыг хууль бусаар мөрдөх нь хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн байна. Энэхүү гэмт хэрэг хувийн сэдэлтээр үйлдэгдэж болно.

<sup>83</sup> С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг”, 2018 он, 102-р тал

<sup>84</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ХҮСНЭГТ 14. ӨМНӨ МӨРДӨГДӨЖ БАЙСАН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ИЖИЛ ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

2002 оны Эрүүгийн хууль		2015 оны Эрүүгийн хууль
Бүлэг	Арван наймдугаар бүлэг Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	Арван гуравдугаар бүлэг Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
Зүйл	132 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих  132.1. Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэнийг ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарласны улмаас гэм хор учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.  134 дүгээр зүйл. Иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгөх  134.1. Иргэнийг улс төрийн нам, төрийн бус байгууллагад сайн дураараа эвлэлдэн нэгдсэний төлөө ялгаварлан гадуурхсан, мөрдөн мөшгөсөн, эрх, эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарласан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, хоёр зуун тавиас гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.  143 дугаар зүйл. Шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх  143.1. Хүнийг шүтэж байгаа шашнаар нь ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх, хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, бусад хэлбэрээр эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	13.12 дугаар зүйл. Хууль бусаар мөрдөж мөшгөх  1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.  Эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгөсөн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Ойролцоо төрлийн гэмт хэрэгт Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих (ЭХ 21.13), Хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах (ЭХ 23.6) гэмт хэргүүд хамаарч байна.

ХҮСНЭГТ 15. ОЙРОЛЦОО ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ХУУЛЬ БУСААР МӨРДӨН МӨШГӨХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

№	Гэмт хэрэг	Объект	Объектив тал	Субъект	Субъектив тал	Хууль бусаар мөрдөн мөшгөх гэмт хэрэгтэй хамааралтай байдал
1	21.13 Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих	Гүйцэтгэх ажил явуулах журам байна	Гүйцэтгэх ажлын тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан идэвхтэй үйлдэл	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан	Гэм буруугийн санаатай хэлбэр	Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих гэмт хэрэг, хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргийн хүндрүүлэх шинжид заасан үйлдлийг субъектийн хувьд тухайн үйл ажиллагааг эрхлэх, хэрэгжүүлэх боломжтой зөвхөн эрх бүхий этгээд байх шинжээрээ ижил байна.
2	23.6 Хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах	Хуульд заасан үндэслэл, журмын дагуу тусгай техник хэрэгсэл ашиглах журам, нэмэгдэл объект нь хүний амьд явах эрх, эрүүл мэндийн халдашгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал	Эрх бүхий мөрдөн шалгах байгууллагын ажилтан, албан тушаалтан хүний амь бие, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хуулиар хориглосон аюултай тусгай техник хэрэгсэл ашигласан идэвхтэй үйлдэл	Эрх бүхий мөрдөн шалгах байгууллагын ажилтан, албан тушаалтан	Гэм буруугийн санаатай хэлбэр	Хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах гэмт хэрэг, хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргийн хүндрүүлэх шинжид заасан үйлдлийг субъектийн хувьд тухайн үйл ажиллагааг эрхлэх, хэрэгжүүлэх боломжтой зөвхөн эрх бүхий этгээд байхаар зүйлчилсэн.

Эрүүгийн эрх зүйн сурах бичигт хууль бусаар мөрдөн мөшгөх гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх, анхаарах асуудлын талаар доорх байдлаар тусгасан байна. Үүнд:

- “Хууль бусаар мөрдөж мөшгөх” болон “Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих”, “Хуулиар хориглосон техник, хэрэгсэл ашиглах” гэмт хэргүүд нь субъектийн хувьд ижил төстэй байх боловч объектив тал буюу тухайн гэмт хэргийн үйлдэгдэх гадаад нөхцөл байдлыг тодорхойлсон хэлбэр үйлдэл нь харьцангуй ялгаатай.
- Хүнийг мөрдөн мөшгөхдөө гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчсөн эсхүл хуулиар хориглосон техник, хэрэгсэл ашигласан бол ЭХТА-ийн 13.12 дугаар зүйл хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэрэг, ЭХТА-ийн 21.13 дугаар зүйл гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчсөн гэмт хэрэг, ЭХТА-ийн 23.6 дугаар зүйл хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах гэмт хэргээр давхар зүйлчилнэ.<sup>85</sup> Энэхүү ойлголтыг эрүүгийн эрх зүйн онолын хүрээнд авч үзвэл нийлмэл гэмт хэрэг<sup>86</sup> гэж тодорхойлох боломжтой.
- Аливаа үйлдлийг хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргээр зүйлчлэх тохиолдолд дараах ойлголтуудын агуулгыг харгалзан үзэх шаардлагатай байна. Үүнд:
  - a. Тухайн мөрдөн мөшгөх үйлдлийг хийхдээ эрх бүхий албан тушаалтан ЭХТА-ийн 21.13 дугаар зүйлд тусгагдсан Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчиж гүйцэтгэсэн эсэхийг шалгах;
  - b. Мөрдөн мөшгөх үйлдлийг хийхдээ эрх бүхий албан тушаалтан ЭХТА-ийн 23.6 дугаар зүйлд тусгагдсан хуулиар хориглосон техник, хэрэгсэл ашигласан эсэхийг шалгах.

#### **4.2. Хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргийг шийдвэрлэж буй байдал**

Монгол Улсад 2017-2019 онд “Хууль бусаар мөрдөн мөшгөх” гэмт хэрийн 7 тохиолдол цагдаагийн албаны ёсны статистикт бүртгэгдсэн<sup>87</sup> бөгөөд 2017 онд 2, 2018 онд 1, 2019 онд 4 хэрэг тус тус бүртгэгджээ. 2020 оны эхний 11 сарын байдлаар энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

<sup>85</sup> С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг”, 2018 он, 103-р тал

<sup>86</sup> С.Нарангэрэл “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, 1999 он, 258-259-р тал

<sup>87</sup> Цагдаагийн байгууллагын статистик мэдээ, 2017-2020 он

Нуугдмал гэмт хэргийн судалгааны дүнгээс үзвэл хууль бус мөрдлөгийн улмаас хохирсон иргэдийн 18.1 хувь нь л хуулийн байгууллагад мэдээлсэн<sup>88</sup> бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн нуугдмал байх магадлал 81.9 хувьтай байна. Нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байх тусам иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, нийгмийн дэг журам алдагдаж, иргэд гэмт хэргээс түгших хандлага нэмэгддэг.

Мөрдөн мөшгөх гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн талаарх мэдээлэл шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайланд тусгагдаагүй байна. Харин Монгол Улсын шүүхийн цахим санд ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлээр шийдвэрлэсэн 1 хэргийн шийтгэх тогтоолын зөвхөн тогтоох хэсгийг хэсэгчлэн авч байршуулжээ. Тухайлбал, 2018 онд Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шүүгдэгч Г-д холбогдох хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийж хүчиндэх гэмт хэргийг, хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргийг, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийг тус тус үйлдсэн гэм буруутайд тооцжээ.

Шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2-т заасныг баримтлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар, 13.12 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тус тус тэнсэж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 450 (дөрвөн зуун тавь) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 450.000 (дөрвөн зуун тавин мянган) төгрөгөөр торгох ялаар шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 3, 7.3 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Г.С-т оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуулийн 21.13 “Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих”, 23.6 “Хуулиар хориглосон тусгай хэрэгсэл ашиглах” зэрэг гэмт хэргийн субъект нь 13.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хүндрүүлэх шинжид хамаарах субъекттэй ижил. Мөн дээрх гэмт хэргүүдийн объектив талын үндсэн шинжийн нөхцөл болох үйлдэл, хор уршиг зэрэг ойлголтууд

<sup>88</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, 2017 он

төстэй байх боловч объектив талын нэмэлт шинж болох гэмт хэрэг үйлдсэн арга, гэмт хэрэг үйлдсэн зэвсэг, хэрэгсэл болон төрлийн объект, шууд объектоороо ялгагдана.

### 4.3. БНТУ-ын Эрүүгийн хуульд тусгагдсан ижил төстэй зохицуулалт

БНТУ-ын Эрүүгийн хуульд хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэрэгтэй ижил төсөөтэй 3 төрлийн зүйл заалт байх бөгөөд тус зүйл заалтууд тухайн хуулийн 9 дүгээр бүлэг “Хүний хувийн эрх, эрх чөлөө хувийн нууцын эсрэг гэмт хэрэг”-т хувийн нууцад халдах, хувийн нууцыг олж авах, хадгалах, хувийн мэдээллийг хуль бусаар олж авах, бусдад дамжуулах гэх томъёоллоор тусгагдсан байна. Үүнд:

#### 134 дүгээр зүйл. Хувийн нууцад халдах

1. Хүний хувийн нууцад халдсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Хувийн нууц мэдээллийг, зураг болон дуу дүрсийг бичлэгт буулган авах хэлбэрээр хувийн нууцад халдсан бол хоёр жилээс зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Хүний хувийн мэдээллийг агуулсан зураг болон дуу дүрсийг хууль бус арга хэлбэрээр нийтэд задалсан, түгээсэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлсэн бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>89</sup>

#### 135 дугаар зүйл. Хувийн нууцыг олж авах, хадгалах

1. Хууль бус арга хэлбэрээр хувь хүний нууц баримт сэлт мэдээллийг олж авсан, хадгалсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Хувийн нууц мэдээлэл нь тухайн хүний улс төрийн үзэл баримтлал, шашин шүтлэг, үндэс угсаа, бэлгийн чиг хандлага, эрүүл мэндийн байдлыг агуулсан бол хоёр жилээс зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>90</sup>

<sup>89</sup> <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>

<sup>90</sup> <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>



### 136 дугаар зүйл. Хувийн мэдээллийг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах

1. Хүний хувийн мэдээллийг хууль бус арга хэлбэрээр бусдад дамжуулсан, түгээсэн эсхүл олж авсан бол хоёр жилээс дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>91</sup>

Монгол Улсын Эрүүгийн хуульд хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэргийн үндсэн шинж нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн байгаа бол БНТУ-ын Эрүүгийн хуульд хувийн нууцад халдах, хувийн мэдээллийг хууль бусаар олж авах бусдад дамжуулах шинжтэй байхаар хуульчилжээ. Эдгээр гэмт хэргийн төрлүүд нь үйлдэл, үйлдэгдэх байдал, үйлдлийн улмаас хүрэх эцсийн зорилго болон гэмт хэргийг үйлдэх субъект зэргээрээ Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан тухайн гэмт хэргүүдээс ялгагдаж байгаа боловч халдлагад өртөгч, халдлагын хэлбэрээрээ адил байна.

#### 4.4. Бүлгийн дүгнэлт

Монгол Улс 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйлдээ “Хууль бусаар мөрдөж мөшгөх” гэмт хэргийг бие даасан зүйл болгон хуульчилснаар Үндсэн хуулиараа баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд нөхөн сэргээх хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд ахиц гаргасан байна.

Хууль тогтоогч 2002 оны Эрүүгийн хуульд байсан иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгөх, жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зөрчих, шүтэж байгаа шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгөх гэмт хэргүүдийг нэгтгэхдээ тухайн гэмт хэргүүдийн нийгмийн аюулын шинж чанар объект, объектив талын шинжүүдийг харгалзан үзэж төрөлжүүлэн системчилсэн байх боломжтой.

2017-2019 онд “Хууль бусаар мөрдөн мөшгөх” гэмт хэрэг нийт 7 бүртгэгдсэнээс шүүхээр шийдвэрлэгдсэн 1 хэрэг байна. Бусад 6 хэргийн хувьд хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх албан ёсны мэдээлэл байхгүй байна.

Шүүхээр шийдвэрлэсэн нэг хэргийн тухайд шүүгдэгчид нэг жилийн хугацаагаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, оршин суух газар, ажил,

<sup>91</sup> <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>

сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авч шийдвэрлэжээ.

Шүүн таслах ажиллагааны мэдээний маягтад Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйл бүртгэгдээгүй байгаа тул энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээллийг олж авахад хүндрэлтэй байна.

## ДҮГНЭЛТ

- Монгол Улсад хууль хэрэгжилтийн илрэл болсон гэмт хэрэг, түүний шийдвэрлэлтийн байдлын талаарх статистик тоон мэдээлэл нь хоорондоо уялдаа холбоо муутай, бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг хэмжихүйц хангалттай түвшинд боловсруулагдахгүй байна. Түүгээр үл барам шинэ төрлийн зарим гэмт хэрэг нь хууль зүйн салбарын статистик мэдээллийг цуглуулах хүснэгтэд огт тусгагдаагүй байгаа тул энэ талаарх мэдээллийг олж авах, нэгтгэх, хууль зүйн салбаруудын хоорондын мэдээллийг харьцуулахад хүндрэлтэй байна.
- Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим мэдээллийн санд энэхүү 4 төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолыг хайхад зарим хэргийг шийдсэн тогтоол илрэхгүй байна. Үүнд үндэслэн тухайн төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхгүй байна гэж шууд дүгнэх боломжгүй юм.
- Зарим тохиолдолд тухайн төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоолын мэдээллийг шүүхийн цахим сангийн “шийдвэрийн дэлгэрэнгүй” хэсэгт алдаатай буруу оруулсан байдал цөөнгүй байна. Энэ нь шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байх, хуулийг нэг мөр, зөв хэрэглэх жишиг тогтоох, судлаач, хуульчид судалгааны ажил хийх зэрэгт сөргөөр нөлөөлөх талтай. Иймээс Шүүхийн Ерөнхий зөвлөл болон УДШ зэрэг эрх бүхий байгууллагаас гаргадаг шүүн таслах ажиллагааны тайланд гэмт хэргийн төрөл, зүйл заалт бүрээр статистик тоон мэдээллийг бүрэн тусгаж байх нь хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх, улмаар эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулахад ач холбогдолтой.
- Шинэ төрлийн гэмт хэрэг, түүний илрэл, хор уршиг, гэмт хэрэгт өртсөн тохиолдолд эрхээ хэрхэн хамгаалах талаарх иргэдийн ойлголт, мэдлэг дутмаг байгаагаас энэ төрлийн гэмт хэргүүд мэдээлэгдэх нь бага, нуугдмал хэвээр байна.

- Сонгогдсон шинэ төрлийн гэмт хэргийн талаарх Эрүүгийн хуулийн зүйл заалтуудыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт зөв ойлгож нэг мөр хэрэглэх явдал дутмаг байна. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын шинэ төрлийн гэмт хэргийн онцлог, хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зүйл, ялангуяа хохирогчийг хамгаалах тогтолцооны талаарх ойлголт, мэдлэг сул байгаагаас хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгох явдал өндөр байгаад анхаарч холбогдох сургалт, сурталчилгааг явуулах хэрэгцээ, шаардлагатай.
- Хуулийг нэг мөр ойлгох хүрээнд албан ёсны тайлбар гараагүй байгаа нь анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй ойлгож хэрэглэх, түүнээс үүдэж сэжигтэн, яллагдагч үндэслэлгүйгээр цагдан хоригдох, эрх зүйн байдал нь дордох, эсхүл эрүүгийн хариуцлагаас мултрах, ял завших зэргээр холбогдогч, хохирогчийн эрхийг зөрчих явдал нэлээдгүй байна.
- Зарим тохиолдолд тодорхой төрлийн хэргийг шийдвэрлэх явцдаа УДШ өөрөө хоёрдмол утга агуулгатайгаар хуулийн зүйл заалтыг тайлбарлаж шийдвэрлэх явдал ч байна.<sup>92</sup> Иймд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх үүднээс УДШ албан ёсны зарим тайлбарыг зайлшгүй хийх шаардлагатай байгаа нь судалгааны явцад харагдлаа.
- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тус хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтооно” гэж заасны дагуу хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх тохиолдолд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хүлээлгэхээр заасан боловч хуулийн энэхүү зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна.

<sup>92</sup> Тухайлбал, УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 16-ны №506 тогтоол болон УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 27-ны №202 тогтоол агуулгын хувьд хоёр өөр байдлаар ойлгогдохоор хууль тайлбарлан хэрэглэжээ.

## ЗӨВЛӨМЖ

### 1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тухайд:

- Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд болон Зөрчлийн тухай хуультай уялдуулж оновчтой тодорхойлох;
- 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “байнга” гэх бүрэлдэхүүний шинж болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хамаарах үйлдлүүд, тэдгээрийн давтамж, үйлдлүүдийн хоорондох хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох, хохирол, хор уршиг шаардах эсэх, давхар зүйлчлэл гэх мэт асуудлыг практикт хэрхэн нэг мөр ойлгож хэрэглэх талаар УДШ-ээс албан ёсоор тайлбар гаргах;
- Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нарт энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд нэн шаардлагатай ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах;
- Шүүхээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хорих ял оногдуулахгүй тэнсэх тохиолдолд үүрэг хүлээлгэх, хязгаарлалт тогтоох албадлагын арга хэмжээнээс аль тохирохыг оногдуулж хэвших, прокурор энэ талаар ялын саналдаа тусгаж, хохирогчийн аюулгүй байдлыг цаашид учирч болзошгүй эрсдэлээс хамгаалахад анхаарах.

### 2. Заналхийлэх гэмт хэргийн тухайд:

- Бусдыг заналхийлж хүчирхийлсэн, эрүүл мэндэд нь хохирол учруулж заналхийлсэн, бусдын орон байранд заналхийлж нэвтэрсэн гэх мэт гэмт хэрэг үйлдсэн хүнд тухайн заналхийллийн нөхцөл байдал, биелэгдэх магадлал, хохирогч, холбогдогчийн харилцаа, хамаарал, цаашид учруулж болзошгүй хор уршиг болон хохирогчийн аюулгүй байдлыг дахин сүрдүүлэг заналхийллээс хамгаалж чадахуйц, үйлдлийнх нь онцлогт тохирсон хариуцлага хүлээлгэх;

- Заналхийлэх гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс хорих ял оногдуулах болон ял оногдуулахгүй тэнсэхдээ ЭХ-ийн 7.2 дугаар зүйлд заасан үүрэг хүлээлгэх, хязгаарлалт тогтоох албадлагын арга хэмжээнээс аль тохирохыг хэрэглэж хэвших;
- 2021 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхлэх ЭХ-ийн 5.5 дугаар зүйлд заасан “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг заналхийлэх гэмт хэрэгт хэрэглэх.

### 3. Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн тухайд:

- Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлд заасан “ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн “эрх, эрх чөлөөг хязгаарласан” гэх объектив талын шинжийг “хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн” гэж өөрчлөх;
- Эрүүгийн хууль ба Зөрчлийн тухай хуульд ялгаварлан гадуурхсан гэмт хэргийн шинжтэй болон гэмт хэргийн шинжгүй үйлдлүүдийг нийгмийн хор аюулын шинж, үр дагавраар нь ялгамжтай томъёолж, хариуцлагын төрөл, хэмжээг тодорхойлох;
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг “ялгаварлах зорилгоор” үйлдсэн бол ЭХТА-ийн 14.1 дүгээр зүйлийн хүндрүүлэх нөхцөл болгон оруулах;
- Албан ёсны тайлан, мэдээлэл гаргадаг хууль хяналтын байгууллагууд бүртгэгдсэн болон хянан шийдвэрлэгдсэн гэмт хэргийн талаарх статистик мэдээллийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, анги бүрээр тодорхой гаргадаг болох;
- Монгол Улсын шүүхийн цахим санд шүүхийн тогтоол байршуулдаг эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь уг сангийн “Шийдвэрийн дэлгэрэнгүй” хэсэгт тусгадаг Эрүүгийн хуулийн Тусгай ангийн зүйл, хэсэг ба Тогтоолын тогтоох хэсгийн утга агуулгыг бүрэн, зөв оруулдаг байх.

### 4. Мөрдөн мөшгөх гэмт хэргийн тухайд:

- Шүүн таслах ажиллагааны тайлангийн маягтад ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийг нэмж оруулах;
- Энэ төрлийн гэмт хэргийн нуугдмал байх магадлал өндөр байгаа тул нэгэнт цагдаагийн байгууллагад мэдээлэгдсэн тохиолдолд хохирогч гомдолгүй гэсэн эсэхээс үл хамаарч хэргийг мухарлан шалгаж шийдвэрлэх.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 оны 1 дүгээр сарын 13
2. Эрүүгийн хуулийн үзэл баримтлал
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 оны 12 дугаар сарын 22
4. Эрүүгийн хууль, 2015 он
5. Шүүхийн тухай хууль
6. ЦЕГ-ын статистик мэдээлэл, 2017-2020 он
7. Монгол Улсын шүүхийн 2020 оны 1-р улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ
8. Монгол Улсын шүүхийн 2019 оны тайлан, [https://judcouncil.mn/site/site/news\\_full/10084](https://judcouncil.mn/site/site/news_full/10084)
9. Монгол Улсын шүүхийн 2020 оны 1 дүгээр улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ
10. “Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь” судалгааны тайлан, Монголын Криминалогичдын холбоо, 2020 он
11. Монгол Улсын шүүхийн 2019 оны тайлан, 221 дүгээр тал [https://judcouncil.mn/site/site/news\\_full/10084](https://judcouncil.mn/site/site/news_full/10084)
12. УДШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 633 дугаар тогтоол
13. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946 оны 12 дугаар сарын 10
14. С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг”, 2018 он
15. Монгол Улсын шүүхийн цахим сан, <http://new.shuukh.mn/eruanhan>
16. <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>
17. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946 оны 12 дугаар сарын 10
18. Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт (Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1968 оны 1 дүгээр сарын 5-нд гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-нд соёрхон баталсан), 26 дугаар зүйл
19. ХЗДХЯ. Монгол Улсын хууль, Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга), Сургагч багш нарт зориулсан гарын авлага
20. <https://police.gov.mn/a/4189>

21. <https://police.gov.mn/a/4867>
22. Монгол Улсын шүүхийн 2018 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны тайлан, 13-14 дэх тал, <http://www.judoinstitute.mn/main/236--2018-.html>.
23. Монгол Улсын шүүхийн 2019 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлан, <http://www.judoinstitute.mn/main/244--2019-3-.html>
24. ЦЕГ-ын МДШШУА-ны Статистик мэдээллийн хэлтсийн мэдээлэл, 2020
25. [file:///C:/Users/User/Downloads/106\\_2020\\_0818\\_%D0%AD\\_2020-10-06\\_868.pdf](file:///C:/Users/User/Downloads/106_2020_0818_%D0%AD_2020-10-06_868.pdf)
26. 2020 оны 10 сарын дугаар 6-ны өдрийн 2020/ШЦТ/868 дугаартай Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол
27. <http://new.shuukh.mn/eruaanhan/37875/view>
28. <http://new.shuukh.mn/eruaanhan/26554/view>
29. Хууль зүйн Үндэсний Хүрээлэн. Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа. Хууль зүйн судалгааны төв, УБ., 2019 он, 26 дахь тал, <http://nli.gov.mn/wp-content/uploads/2019/07/yalgawarlan-gaduurhah.pdf>
30. <http://stykrf.ru/111>
31. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_34661/8b36cedfef8c1b205cdbc85ee7a7dc250f5109/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/8b36cedfef8c1b205cdbc85ee7a7dc250f5109/)
32. <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf>
33. Хууль зүйн Үндэсний Хүрээлэн. Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах эсэх талаарх хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаа. Хууль зүйн судалгааны төв, УБ., 2019 он, 26 дахь тал <http://nli.gov.mn/wpcontent/uploads/2019/07/yalgawarlan-gaduurhah.pdf>
34. С.Нарангэрэл “МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ Ерөнхий анги”, 1999 он, 258-259-р тал.
35. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, 2017 он





ISBN 991997421-8



9 789919 974213